

САНХҮҮГИЙН
МЭДЭЭЛЛИЙН АЛБА

2023

жилийн тайлан

АГУУЛГА

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ МЭНДЧИЛГЭЭ

БҮЛЭГ I.

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС МЭДЭЭЛЭЛ
ХҮЛЭЭН АВАХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ / 9

1.1. Мэдээлэл цуглуулах болон дүн шинжилгээ хийх / 10

1.2. Мэдээлэл солилцох / 17

1.2.1. Дотоодын эрх бүхий байгууллагуудтай
мэдээлэл солилцож, хамтран ажилласан байдал / 17

1.2.2. Гадаадын эрх бүхий байгууллагуудтай
мэдээлэл солилцож, хамтран ажилласан байдал / 19

БҮЛЭГ II.

ДОТООД БА ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА / 21

2.1. Дотоод хамтын ажиллагаа / 22

2.2. Гадаад хамтын ажиллагаа / 27

2.2.1. Харилцан ойлголцлын санамж бичиг / 27

2.2.2. Гадаад хамтын ажиллагаа /ФАТФ, АНДМУТБ,
ЕАМУТБ, Эгмонт бүлэг / 28

2.2.3. Олон улсын хамтын ажиллагаа / 30

БҮЛЭГ III.

ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИК
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ / 33

БҮЛЭГ IV.

ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ,
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА / 41

4.1. Холбогдох байгууллагуудад
хийсэн сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа / 42

4.2. Санхүүгийн мэдээллийн албаны
ажилтнуудын хамрагдсан сургалт / 44

БҮЛЭГ V.

МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ / 45

5.1. Мэдээллийн ситемийн шинэчлэл /гоАМЛ/ / 46

БҮЛЭГ VI.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ / 49

БҮЛЭГ VII.

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨР / 55

7.1. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт / 56

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ



ХҮСНЭГТ 1.

Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн гүйлгээний тоо, тайлангийн төрлөөр /10

ХҮСНЭГТ 2.

Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн гүйлгээний тоо, салбараар, 2023 он /11

ХҮСНЭГТ 3.

Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн бэлэн мөнгөний гүйлгээний тоог өмнөх онтой харьцуулсан байдлаар, салбараар, 2021-2023 он /12

ХҮСНЭГТ 4.

Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоог өмнөх онтой харьцуулсан байдлаар, салбараар, 2021-2023 он /12

ХҮСНЭГТ 5.

Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн сэжигтэй гүйлгээний тоог өмнөх онтой харьцуулсан байдлаар, салбараар, 2021-2023 он /13

ХҮСНЭГТ 6.

Гаалийн мэдүүлгийн тоо /2021-2023/ /14

ХҮСНЭГТ 7.

Сэжигтэй гүйлгээний тоо болон дүн шинжилгээ хийгдсэн, хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо /2021-2023/ /15

ХҮСНЭГТ 8.

Санхүүгийн мэдээллийн албаас дотоодын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцсон байдал /17

ХҮСНЭГТ 9.

Гадаад улсын Санхүүгийн мэдээллийн албатай мэдээлэл солилцсон байдал /20

ХҮСНЭГТ 10.

Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн үнэлгээ /37

ХҮСНЭГТ 11.

Олон улсын байгууллагуудаас зохион байгуулсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлээр сургалт, конференц, форум, вэбинарын жагсаалт /42

ХҮСНЭГТ 12.

Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын сургалт, семинарт хамрагдсан байдал /44

ХҮСНЭГТ 13.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа /2021-2023 он/ /51

ХҮСНЭГТ 14.

Хөтөлбөрийн зорилго /57

ХҮСНЭГТ 15.

Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжүүлэх хугацаа /59

ЗУРГИЙН ЖАГСААЛТ



ЗУРАГ 1.

Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн сэжигтэй гүйлгээний тайлангийн эхний 10 сэжигтэй үндэслэл. 2023 он /14

ЗУРАГ 2.

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн /22

ЗУРАГ 3.

Хамтын ажиллагааны зөвлөлийн бүрэлдэхүүн /24

ЗУРАГ 4.

Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх дэд ажлын хэсгүүд /25

ЗУРАГ 5.

Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан улс орнууд /27

ЗУРАГ 6.

Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макаогийн Санхүүгийн мэдээллийн албатай санамж бичиг солилцов /28

ЗУРАГ 7.

Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Санхүүгийн мэдээллийн албатай санамж бичиг солилцов /28

ЗУРАГ 8.

АНУ-ын Сангийн яамны зөвлөхтэй хамтарсан сургалт /32

ЗУРАГ 9.

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 25 дахь удаагийн Жилийн уулзалт /34

ЗУРАГ 10.

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 25 дахь удаагийн Жилийн уулзалт /36

ЗУРАГ 11.

Монгол Улсын 2023 оны явцын тайлан /38

ЗУРАГ 12.

Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн үнэлгээний хуваарилалт /38

ЗУРАГ 13.

гоАМЛ программын цахим хуудас /46

ЗУРАГ 14.

гоАМЛ программд бүртгүүлсэн мэдээл үүрэгтэй этгээдийн тоо, салбараар, 2023 он /47

ЗУРАГ 15.

Хөтөлбөрийн бүтэц /56

ЗУРАГ 16.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд /58

ЗУРАГ 17.

Хөтөлбөрийн биелэлтийг ҮЗ, ХАЗ-ийн хуралд танилцуулсан байдал /58

ЗУРАГ 18.

2023 онд хийгдэж дуусгахаар тусгагдсан ажлуудын биелэлтийн байдал /59

МЭНДЧИЛГЭЭ

Санхүүгийн мэдээллийн албаны хувьд 2023 он мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ахиц дэвшил гаргасан, сорилт, сургамжаар дүүрэн жил байлаа. Ингэхдээ Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийг (Зөвлөмж 15-ыг шинэчилсэн үнэлгээгээр) бүрэн биелүүлсэн үнэлгээтэй Ази, Номхон далайн орнуудаас анхны, дэлхийн улсуудаас 5 дахь орон болсон. Энэ бол Санхүүгийн мэдээллийн алба төдийгүй төр, хувийн хэвшлийн байгууллагууд, мэргэжлийн холбоод болон олон улсын донор байгууллагуудын идэвх зүтгэлтэй хамтын ажиллагааны үр дүн бөгөөд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Монгол Улс шаардлагатай хууль эрх зүй, зохицуулалтын орчныг бий болгон ажиллаж байгааг олон улсаас баталгаажуулж буй явдал боллоо.

Тайлант онд Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн сэжигтэй гүйлгээний тоо өмнөх оноос 30 гаруй хувиар, бэлэн мөнгөний гүйлгээний тоо өмнөх оноос 10 орчим хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Энэхүү бууралтын шалтгаан нь дийлэнх мэдээлэх үүрэгтэй этгээдүүд их дүнтэй гүйлгээг сэжигтэй гүйлгээ байдлаар илгээдэг байсан бөгөөд сэжигтэй гүйлгээ мэдээлэхтэй холбоотой сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулсны үр дүнд мэдээлэх үүрэгтэй этгээдүүд өөрсдийн харилцагчдаа бодитоор үнэлж гүйлгээний мэдээллээ ирүүлдэг болсон. Харин гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо 23 хувиар өссөн бол виртуал хөрөнгийн гүйлгээний тоо 3 дахин өсжээ. Санхүүгийн мэдээллийн алба энэ онд нийт 790 гаруй сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 124% өссөн үзүүлэлттэй байлаа.



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй байдаг. Иймд Санхүүгийн мэдээллийн алба нь Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгч ажиллаа. Энэ хүрээнд Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд, мэргэжлийн холбоодын үндсэн чиг үүрэгт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай тодорхой тусгах, хариуцсан ажилтныг томилон ажиллуулах тухай зөвлөмж гаргах, Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх ажлын хэсгийн төлөөлөгөө болон бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах, Судалгаа, дүн шинжилгээний ажлын хэсэгт хувийн хэвшлийн төлөөллүүдийг оролцуулах, Монгол Улсын 7 дахь шатны Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлэхээр шийдвэрлэх зэрэг асуудлуудыг төрийн 19 байгууллагын оролцоотой төлөөллүүд нийт 5 удаа хуралдан хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гарган ажиллалаа.

Түүнчлэн гадаад хамтын ажиллагааг сайжруулах хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Санхүүгийн мэдээллийн албатай Харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Ийнхүү Санхүүгийн мэдээллийн алба нь 2023 оны байдлаар нийт 23 орны Санхүүгийн мэдээллийн албатай хоёр талын мэдээлэл солилцох харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж ажиллав. Мөн манай улс ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2023 онд дэлхийн улс орнуудын шинэ технологитой холбоотой Зөвлөмж 15-ын хэрэгжилтийг сайжруулах ажлуудыг идэвхтэй зохион байгуулж ажилласны үр дүнд Монгол Улсын туршлагыг сайн жишигт тооцож, улмаар

Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо хамтран 2023 оны 5 дугаар сард Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн ажлын хэсгийн уулзалтаар виртуал хөрөнгийн салбарт хийсэн эрсдэлийн үнэлгээний талаар илтгэл танилцуулсан. Тус бүлгийн 2023 оны 12 дугаар сард зохион байгуулсан Типологийн жилийн уулзалтаар мөн Монгол Улсын туршлагыг танилцуулан панел хэлэлцүүлэгт оролцсон.

Үүнээс гадна Санхүүгийн мэдээллийн албаны болон бусад хяналт шалгалтын байгууллагуудын ажилчдын чадавхыг бэхжүүлэх, сүүлийн үеийн чиг хандлагын талаар мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр гадаад болон дотоодын мэргэжлийн сургалт, семинарт тогтмол хамруулах ажлыг оны турш зохион байгууллаа. Ингэхдээ Санхүүгийн мэдээллийн алба дангаараа болон бусад байгууллагатай хамтран нийт 50 гаруй төрлийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 3800 гаруй албан хаагчид сургалтад хамрагдлаа. Түүнчлэн Дэлхийн банкны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Монголын Улсын банкуудын корреспондент харилцааг сайжруулахад тулгамдаж буй асуудлуудын талаар дотоодын зөвлөхүүдтэй хамтран судалгаа хийлээ. Мөн Санхүүгийн мэдээллийн албанаас бусад төрийн байгууллагуудтай хамтран мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлж, соён гэгээрүүлэх чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаа.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг баталж 2022-2030 онуудад үндсэн 8 зорилгын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн билээ. Энэ хүрээнд Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2023 онд баталж нийт 194 ажлыг тусгасан

бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг бид энэ онд эхлүүллээ. Үүнтэй холбоотойгоор Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд улирал бүр хуралдаж арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллаа. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх 21 ажлаас 15 нь бүрэн биелсэн, 6 нь хэрэгжилтийн явцдаа явж байна. Жил бүр тогтмол хийж хэрэгжүүлэх 30 ажлаас 29 ажлыг бүрэн дуусгаж 1 ажил хэрэгжилтийн явцдаа үргэлжилж байна. Түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 7 заавар, зөвлөмж, гарын авлагыг гаргаж мөн 7 журам, маягыг шинэчилж баталсан байна. Үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлснээр бид Монгол улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх урт хугацааны зорилтоо тодорхойлж чадсан төдийгүй 2028-2029 онд хийгдэх Монгол улсын дараагийн шатны харилцан үнэлгээний үр дүнтэй байдалд түлхэц болно гэж харж байна.

Энэ дашрамд Санхүүгийн мэдээллийн албатай хамтран ажилладаг Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд, мэргэжлийн холбоод, мэдээлэх үүрэгтэй этгээдүүд, олон улсын донор байгууллагуудад хамтран ажилладагт чин сэтгэлийн талархал илэрхийлье!

Хүндэтгэсэн,

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН
АЛБАНЫ ДАРГА Б.БАТБААТАР

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

**МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ
ЭТГЭЭДЭЭС МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН
АВАХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ**

1.1. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ БОЛОН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэх үүрэгтэй этгээд¹ нь сэжигтэй гүйлгээний мэдээлэл болон 20 сая төгрөг, түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ, гадаад төлбөр тооцооны гүйлгээ, виртуал хөрөнгийн гүйлгээний мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн мэдээллийн албаны 2023 онд хүлээн авсан мэдээллийг гүйлгээний төрлөөр ангилж өмнөх хоёр онтой харьцуулан (Хүснэгт 1) харуулав.

Хүснэгт 1. СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн гүйлгээний тоо, тайлангийн төрлөөр

	2021 ОН	2022 ОН	2023 ОН
 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТОО	1,801	2,626	1,799
БЭЛЭН МӨНГӨНИЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТОО	336,518	349,126	315,103
ГАДААД ТӨЛБӨР ТООЦООНЫ ГҮЙЛГЭЭНИЙ ТОО	211,176	230,402	284,301
ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ГҮЙЛГЭЭНИЙ ТОО	-	1,783	7,447

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

¹ 4.1.1. банк;
4.1.2. банк бус санхүүгийн байгууллага;
4.1.3. даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;
4.1.4. хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;
4.1.5. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
4.1.6. хадгаламж, зээлийн хоршоо;
4.1.7. үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;
4.1.8. энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээнд оролцсон бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;
4.1.9. нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн харилцагчтай холбоотой дараах ажиллагааг бэлтгэсэн, хийсэн, эсхүл оролцсон бол:
4.1.9.а. үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
4.1.9.б. харилцагчийн хөрөнгийг удирдах;
4.1.9.в. банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;
4.1.9.г. компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;
4.1.9.д. хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.
4.1.10. виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч;
4.1.11. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд.

Монгол Улсад виртуал хөрөнгийн салбарын хууль, эрх зүйн орчин бүрдэж, 2021 оны 12 дугаар сард Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдсан. Үүнтэй холбоотойгоор Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид нь мэдээлэх үүрэгтэй этгээд болсон ба 2022 оны 10 дугаар сараас эхлэн 20 сая төгрөг, түүнээс дээш дүнтэй виртуал хөрөнгийн гүйлгээний мэдээлэл болон сэжигтэй гүйлгээний мэдээллийг хуульд заасны дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлж байна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сард Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг баталсантай холбоотойгоор тус хуульд заасан мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь мэдээлэх үүрэгтэй этгээд болсон.

Ийнхүү 2023 оны байдлаар нийт 11 төрлийн мэдээлэх үүрэгтэй этгээд хуульд заасан гүйлгээний мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэг хүлээж байгаа бөгөөд эдгээр мэдээлэх үүрэгтэй этгээдээс тайлант онд мэдээлсэн гүйлгээний мэдээллийг салбараар ангилж (Хүснэгт 2) харууллаа.

Хүснэгт 2. СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн гүйлгээний тоо, салбараар, 2023 он

		Сэжигтэй гүйлгээ		Бэлэн мөнгөний гүйлгээ		Гадаад төлбөр тооцооны гүйлгээ	
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
	Нийт	1,799	100%	315,103	100%	284,301	100%
1	Банк	1,490	82.8%	305,546	96.9%	276,125	97.1%
2	Банкнаас бусад санхүүгийн байгууллага	106	5.9%	8,891	2.8%	8,168	2.9%
3	СББМҮҮ ²	147	8.2%	666	0.2%	8	0.003%
4	ВХҮҮ ³	56	3.1%	-	-	-	-

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн 20 сая төгрөг, түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ, гадаад төлбөр тооцооны гүйлгээ, виртуал хөрөнгийн гүйлгээ болон сэжигтэй гүйлгээний мэдээллийг салбараар ангилж өмнөх онтой харьцуулан (Хүснэгт 3, 4, 5) харуулав.

² Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч

³ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч

Хүснэгт 3. СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн бэлэн мөнгөний гүйлгээний тоог өмнөх онтой харьцуулсан байдлаар, салбараар, 2021-2023 он

МҮЗ-ийн төрөл	Он	2021 он		2022 он		2023 он		2023 / 2022 харьцуулсан өөрчлөлт
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	
Бэлэн мөнгөний гүйлгээний тоо		336,518	100%	349,126	100%	315,103	100%	▼ 9.74%
Банк		317,520	94.40%	335,305	96.04%	305,546	96.97%	▼ 8.87%
Банкнаас бусад санхүүгийн байгууллага		17,836	5.30%	11,527	3.30%	8,891	2.82%	▼ 22.8%
СББМҮҮ		862	0.30%	2,293	1%	666	0.21%	▼ 70.95%
ВХЗҮҮ		-	-	1	-	1	-	

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Бэлэн мөнгөний гүйлгээний тоо 2023 онд өмнөх жилийнхтэй харьцуулахад бүх салбарт буурсан үзүүлэлттэй байна. Монгол Улсад төлбөрийн системийн шинэчлэл тасралтгүй хийгдэхийн зэрэгцээ бэлэн бус төлбөр тооцоо өнгөрсөн 2 жилийн хугацаанд 2 дахин нэмэгдсэн, мөн шинэ техник технологид суурилсан төлбөрийн хэрэгслүүд олноор нэвтэрснээр бэлэн бус төлбөр тооцоо хийхэд улам хялбар, зардал багатай болж байна. Үүнтэй холбогдуулан иргэд бэлэн мөнгөнөөс илүүтэй бэлэн бус төлбөр тооцоо, санхүүгийн хэрэгсэл ашиглах, цахимаар гүйлгээ хийх сонирхолтой болж байгаа нь бэлэн мөнгөний гүйлгээний тоо буурч байгаатай холбоотой гэж үзэж байна⁴.

Хүснэгт 4. СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоог өмнөх онтой харьцуулсан байдлаар, салбараар, 2021-2023 он

МҮЗ-ийн төрөл	Он	2021 он		2022 он		2023 он		2023 / 2022 харьцуулсан өөрчлөлт
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	
Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо		211,176	100%	230,402	100%	284,301	100%	▲ 23.39%
Банк		201,176	95.50%	221,883	96.30%	276,125	97.12%	▲ 24.44%
Банкнаас бусад санхүүгийн байгууллага		9,222	4.40%	8,517	3.69%	8,168	2.96%	▼ 4.09
СББМҮҮ		190	0.10%	2	0.09%	8	0.10%	▲ 300%
ВХҮҮ		-	-	-	-	-	-	

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

⁴ Монголбанк. (2022). Төв банкны цахим мөнгөний чиг хандлага, үр дүн, анхаарах асуудал.

Гадаад төлбөр тооцооны гүйлгээний статистик тоог харвал 2021 оноос хойш тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Монгол Улс 2023 онд нийт 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны бараа эргэлт 24.4 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 3.2 тэрбум ам.доллараар өссөн, үүнээс экспорт 2.6 тэрбум ам.доллараар, импорт 548.1 сая ам.доллараар өссөн нь гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо өсөхөд шууд нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 5. СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн сэжигтэй гүйлгээний тоог өмнөх онтой харьцуулсан байдлаар, салбараар, 2021-2023 он

2021-2023 онд МҮЭ-ээс мэдээлсэн СГТ, өмнөх онтой харьцуулсан байдлаар							
	2021		2022		2023		2023 оныг 2022 онтой харьцуулсан өөрчлөлт
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	хувь
НИЙТ	1,801	100%	2,626	100%	1,799	100%	▼ 31.49%
Санхүүгийн байгууллага							
Банк	1,758	97.61%	2,281	86.86%	1,490	82.82%	▼ 34.68%
ББСБ	21	1.17%	35	1.33%	53	2.95%	▲ 51.43%
Даатгал	-	-	-	-	-	-	-
ХОС, ХОМК	-	-	-	-	-	-	-
ҮЦЗЗОМБ	2	0.11%	0	0	53	2.95%	-
ХЗХ	-	-	-	-	-	-	-
Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч							
ҮХЭХЗБ	5	0.28%	41	1.56%	24	1.33%	▼ 41.46%
ҮМҮЧТХЭАЭ	-	-	-	-	-	-	-
Нотариатч	6	0.33%	70	2.67%	78	4.34%	▲ 11.43%
Хуульч	-	-	-	-	35	1.95%	-
НББСЗҮҮ	4	0.22%	5	0.19%	10	0.56%	▲ 100%
Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч							
ВХҮҮ	-	0	161	6.13%	56	3.11%	-65.22%
Бусад							
Бусад	5	0.28%	33	1.26%	0	-	▼100%

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Тайлант онд мэдээлэх үүрэгтэй этгээд нийт 1,799 сэжигтэй гүйлгээ мэдээлсэн бөгөөд энэ нь 2022 онтой харьцуулахад 31.5 хувиар буурсан байна. Үүнд банкнаас мэдээлсэн сэжигтэй гүйлгээний тоо 34.7 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин банкнаас бусад санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдээс ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тоо өмнөх онтой харьцуулахад өссөн дүнтэй байна. Мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн сэжигтэй гүйлгээний сэжиглэх үндэслэлээр ангилж харвал хамгийн олон тоотой ирүүлсэн эхний 10 сэжиглэх үндэслэл дараах байдалтай байна (Зураг 1).

Зураг 1. СМА-нд мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлсэн сэжигтэй гүйлгээний тайлангийн эхний 10 сэжиглэх үндэслэл, 2023 он

Мөрийтэй тоглоом эсхүл тусгай зөвшөөрөлгүй төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа	14.7%	
Байгууллагын гүйлгээг хувийн дансаар хийж, татвараас зайлсхийсэн байж болзошгүй	13.6%	
Татвараас зайлсхийсэн байж болзошгүй	9.8%	
Эх үүсвэр тодорхойгүй эдийн засгийн үндэслэлгүй гүйлгээ	5.4%	
Цахим залилантай холбоотой байх магадлалтай	5.1%	
Виртуал хөрөнгө /Крипто валюттай холбоотой сэжигтэй гүйлгээ	4.9%	
Бусад	4.8%	
Тусгай зөвшөөрөлгүй санхүүгийн үйл ажиллагаа явуулсан байж болзошгүй	4.5%	
Харилцагчийн үйлдэл, гүйлгээний дүн, давтамж, хийж буй хэлбэр нь сэжигтэй	3.6%	
Гүйлгээний хэв маяг, дүн огцом өөрчлөгдсөн эсхүл утга, зориулалт тодорхойгүй, эдийн засгийн	3.6%	

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Санхүүгийн мэдээллийн албанаас 2023 онд сэжигтэй гүйлгээний тайлангийн чанарыг сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч ажилласан бөгөөд мэдээлэх үүрэгтэй этгээдтэй тогтмол уулзалт зохион байгуулж, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор сэжигтэй гүйлгээний чанар, хийсэн дүн шинжилгээний талаарх ерөнхий мэдээлэл, сэжигтэй гүйлгээний нийтлэг хэв шинж, арга хэлбэрийн талаар мэдээлэл өгч ажиллав. Түүнчлэн Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр мөнгө угаахад ашиглагдах эрсдэл өндөр гэж үнэлэгдсэн салбар болон өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргээс түүвэрлэн “Гадаад улсаас гаралтай хууль бус мөнгийг Монгол Улсын санхүүгийн системээр дамжуулан угаах нь”, “Үл хөдлөх хөрөнгө ашиглан мөнгө угаах нь”, “Улс төрд нөлөө бүхий этгээд” сэдвээр типологийн тайлан боловсруулж мэдээлэх үүрэгтэй этгээдэд хүргүүлсэн болно.

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлсэн 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгөний гаалийн мэдүүлгийг гаалийн байгууллагаас сар бүр хүлээн авдаг (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Гаалийн мэдүүлгийн тоо /2021-2023/

ГААЛИЙН МЭДҮҮЛГИЙН ТОО	2021	2022	2023
	2,660	30,151	15,090

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Монгол Улсын хэмжээнд зорчигчийн бэлэн мөнгөний мэдүүлэг 2022 онтой харьцуулахад 2023 онд 50 хувиар бага бүртгэгдсэн байгаа нь Ковид-19 цар тахлын хязгаарлалтууд цуцлагдаж иргэд, жуулчдын хөдөлгөөн 2022 онд огцом нэмэгдсэн нь 2023 онд харьцангуй буурсан, мөн зорчигчид бэлэн мөнгөнөөс илүүтэй бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл, төлбөрийн карт ашиглах сонирхол өндөртэй болсонтой холбоотой гэж үзэж болохоор байна.

Санхүүгийн мэдээллийн албаны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн нэг нь мэдээлэх үүрэгтэй этгээдээс хүлээн авсан сэжигтэй гүйлгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийх юм. 2023 онд дүн шинжилгээ хийсэн сэжигтэй гүйлгээний тоо 795 болж, өмнөх онтой харьцуулахад 124 хувиар өсөв (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Сэжигтэй гүйлгээний тоо болон дүн шинжилгээ хийгдсэн, хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо /2021-2023/

	2021 ОН	2022 ОН	2023 ОН
 сэжигтэй гүйлгээний тоо	1,801	2,626	1,799
дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо	551	354	795

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба



ШИГТГЭЭ 1. ГАДААД УЛСААС ГАРАЛТАЙ ХУУЛЬ БУС МӨНГИЙГ МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН УГААХ НЬ

Монгол Улсын 2 дахь удаагийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр гадаад улсаас гаралтай хууль бус эсвэл эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгийг Монгол Улсын санхүүгийн системээр дамжуулан угаах аюул заналын үнэлгээг “Өндөр” хэмээн үнэлсэн. Үүнтэй холбогдуулан энэ төрлийн мөнгө угаахтай холбогдох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гадаад улсаас гаралтай хууль бус эсвэл эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгийг Монгол Улсын санхүүгийн системээр дамжуулан угааж байж болзошгүй гүйлгээг таньж илрүүлэн эрх бүхий байгууллагад мэдээлэх чиглэлээр арга хэлбэр%, шинж тэмдэг, авах арга хэмжээний талаар ойлголт өгөх зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас типологийн тайлан боловсруулж гаргав.

Тус типологийн тайланд энэ төрлийн гэмт хэрэг, холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт, түгээмэл типологиуд, мөнгө угаасан кейсүүд, шинж тэмдгүүд болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг дэлгэрэнгүй дурдсан. Тухайлбал, гадаад улсаас гаралтай их хэмжээний мөнгөн хөрөнгийг (i) мөнгө угаах, (ii) терроризмыг санхүүжүүлэх, (iii) үй олноор хөнөөх, зэвсэг дэлгэрүүлэхийг

санхүүжүүлэх, (iv) хориг арга хэмжээнээс зайлсхийх зорилгоор Монгол Улсын санхүүгийн системээр дамжуулж болох бөгөөд мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчтай харилцах үедээ дараах шинж тэмдгүүдийг анхаарвал зохистой. Үүнд:

- Гаднаас орж ирсэн их хэмжээний мөнгөн хөрөнгийг эдийн засгийн үндэслэлгүйгээр олон хэсэгт жижиглэн хувааж шилжүүлэх
- Орж ирсэн мөнгөн хөрөнгийг валют арилжаанд оруулж эргэлдүүлэх
- Гүйлгээний утгыг хуурамчаар үйлдэж, аливаа хууль ёсны бизнесийн үйл ажиллагаанаас олсон ашиг мэт харагдуулах байдлаар тухайн мөнгөн хөрөнгийн хэлбэрийг банкны мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан өөрчлөх. Жишээ нь: “бараа бүтээгдэхүүний худалдан авалт” гэж бичих.
- Гэмт этгээд нь гэмт хэрэгт хамааралгүй бусад этгээдийн дансыг ашиглах. Шан харамж өгөх байдлаар ашиглаж аливаа мөнгөн хөрөнгийг шилжүүлэх.
- Дансанд шилжиж орж ирсэн мөнгийг ихэвчлэн бэлнээр зарлагадах
- Дансанд шилжиж орж ирсэн мөнгөнөөс хэвийн бус, өндөр дүн бүхий зарлага тогтмол гаргах
- Хийгдэж буй гүйлгээ нь харилцагчийн мэдээлэл, үйл ажиллагаатай нийцэхгүй байх

Типологийн тайланд дурдсан гадаад улсаас гаралтай мөнгийг Монгол Улсаар дамжуулан угаасан кейсийг энд танилцуулья:

“А” улсын “Б” иргэн “В” улсын хөрөнгө оруулалттай “Г” гэх компанийг 2011 онд Монгол Улсад үүсгэн байгуулсан. Тус компани нь гадаад худалдаа, бизнесийн зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хэмээн Монгол Улсын арилжааны банкуудад төгрөг болон валютын дансууд нээж, 2015-2019 онд гадаад улсаас 54 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний шилжүүлэг хүлээн авсан байна. Улмаар хүлээн авсан мөнгөө банкны гадаад гуйвуулгын үйлчилгээгээр оффшор бүсэд бүртгэлтэй 10 улс руу шилжүүлсэн байна. Үүнээс гадна иргэн “Б” нь компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байхдаа тус компанийн 2014-2019 оны хоорондох татвар ногдох орлогоос нийт 222 сая төгрөгийн их хэмжээний татварыг төлөхөөс зайлсхийжээ. Шүүхээс гэм буруутай этгээдийг дээрх мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах зорилгоор гадаад улсууд руу байнга шилжүүлэн мөнгө угааж Эрүүгийн хуулийн 18.3 дугаар зүйлийн 1 /Татвар төлөхөөс зайлсхийх/, 18.6 дугаар зүйлийн 2.2-т /Мөнгө угаах/ заасан гэмт хэргийг үйлдсэн гэмт буруутайд тооцон 2 жилийн хугацаагаар хорих ялыг оноож, шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан данснаас 445 сая төгрөгийг албадан гаргуулж улсын орлого болгуулахаар шийдвэрлэсэн байна.

1.2.МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

1.2.1.Дотоодын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцож хамтран ажилласан байдал

Санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр дотоодын эрх бүхий хууль сахиулах байгууллагатай мэдээлэл солилцон хамтран ажиллаж, гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилладаг. Энэ хүрээнд 2023 онд дараах байдлаар мэдээлэл солилцож ажиллав (Хүснэгт 8).

Хүснэгт 8. СМА-наас дотоодын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцсон байдал

	2021	2022	2023
СМА-НААС ДОТООДЫН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДАД ШАЛГУУЛАХААР ШИЛЖҮҮЛСЭН СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТОО	539	324	765
МЭДЭЭЛЭЛ АВАХ ЗОРИЛГООР ДОТООДЫН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДААС СМА-НД ИРҮҮЛСЭН ХҮСЭЛТ /ЭТГЭЭДИЙН ТООГООР/	3,665	7,148	5,613
ДОТООДЫН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДААС СМА-НД ИРҮҮЛСЭН ХҮСЭЛТИЙН ДАГУУ ЯВУУЛСАН ХАРИУ /ЭТГЭЭДИЙН ТООГООР/	3,834	6,749	5,948

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Үүнээс гадна Санхүүгийн мэдээллийн алба нь цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор дотоодын эрх бүхий хууль сахиулах байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилладаг. Энэ хүрээнд Монголбанк, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар хамтарсан Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах”, 20.17 дугаар зүйлд заасан “Мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэргийг илрүүлэх, хууль бус үйлдлийг саармагжуулах зорилготой арга хэмжээнд Санхүүгийн мэдээллийн албанаас идэвхтэй хамтран ажиллав.



ШИГТГЭЭ 2. ЦАХИМ МӨРИЙТЭЙ ТОГЛООМ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дэлхий даяар цахим мөрийтэй тоглоомын зах зээл маш хурдацтай хөгжиж байгаа бөгөөд 2019 онд 50 тэрбум ам.долларын зах зээлийн эргэлттэй байсан бол 2026 онд 2 дахин өсөх буюу 100 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна гэж олон улсын судалгаанд харуулжээ. Технологийн дэвшлийн нөлөөгөөр гар утасны программуудаар дамжуулан цахим платформуудыг ашиглан цахим тоглоом тоглох боломжтой болсноор энэ зах зээл хурдацтай өсөж байна. Түүнчлэн дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хүмүүс хөл хорионд орж, хоорондоо биечлэн харилцах нь багассанаас болж гэрээс гаралгүй чөлөөт цагаа өнгөрөөх нэг арга нь цахимаар тоглоом тоглох болжээ. Интернет төлбөр тооцооны технологийн хөгжил дэвшил нь цахим гүйлгээ, гуравдагч этгээдээр дамжуулан төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч, цахим түрийвч хэрэглэгчдийн тоо өсөх, цахим тоглоомын зах зээл өргөжихөд ч нөлөө үзүүлсэн байна.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд цахим орчинд хууль бус мөрийтэй тоглоом зохион байгуулах үзэгдэл ихсэж, үүнийг даган гарах нийгмийн сөрөг үр дагавар ихэссээр байна. Үүнтэй холбогдуулан 2023 онд цахим орчинд хууль бус мөрийтэй тоглоом зохион байгуулагчидтай тэмцэх, таслан зогсоох зорилгоор Монголбанк, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар хамтран ажилласан. Уг арга хэмжээний хүрээнд 2,715 данс, эдгээр дансанд төвлөрсөн байсан 4,6 тэрбум төгрөгийг царцаасан байна.

Санхүүгийн мэдээллийн алба нь хууль сахиулах байгууллагатай мэдээлэл солилцож хамтран ажиллахаас гадна хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор бусад эрх бүхий байгууллагууд, тухайлбал Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газруудтай мэдээлэл солилцож хамтран ажилласан болно.



ШИГТГЭЭ 3. ЦАХИМ ЗАЛИЛАН

Дэлхий дахинаа сүүлийн жилүүдэд цахимаар үйлдэгддэг төрөл бүрийн гэмт хэрэг, тэр дундаа цахимаар залилан хийх явдал ихсэж байгаа бөгөөд үүнд санхүүгийн байгууллагууд, бизнес эрхлэгчид, хувь хүмүүс өртөж санхүүгийн болон сэтгэлзүйн хувьд их хэмжээний хохирол амсаж байна. Монгол Улсын хувьд ч богино хугацаанд их мөнгөтэй болох гэсэн эсвэл мөнгөө өсгөх үүднээс сайтар нягтлалгүйгээр санхүүгийн харилцаанд орсноос хохирогч болсон иргэд, аж ахуйн нэгжийн тоо сүүлийн үед эрс нэмэгдэж байна.

Манай улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хоёр дахь удаагийн үндэсний эрсдэлийн үнэлгээгээр “залилах” гэмт хэргийн улмаас олсон орлогоос үүдэлтэй аюул занал “өндөр” гэж үнэлэгдсэн. Цагдаагийн ерөнхий газраас мэдээлснээр сүүлийн таван жилийн хугацаанд 14,085 залилах гэмт хэрэг бүртгэгдсэнээс 97 хувь нь цахим орчинд үйлдэгдсэн байна. Цахим орчинд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн тоо өнгөрсөн таван жилд 14 дахин, учирсан хохирлын хэмжээ 270 дахин өссөн бөгөөд зөвхөн сүүлийн нэг жилд цахим гэмт хэргийн хохирлын хэмжээ 7.5 дахин өсөж, 139 тэрбум төгрөгт хүрчээ.

Цахим залилангийн шинжтэй гүйлгээг нэгэнт хийсэн бол 24 цаг өнгөрснөөс хойш ихэнх тохиолдолд буцааж авах боломж маш бага болдог тул банк, санхүүгийн байгууллагууд болон тэдний харилцагчид хугацаа өнгөрөх тусам гүйлгээг цуцлах, мөнгөө буцааж авах боломжгүй байдаг. Иймд санхүүгийн байгууллагын ажилтан гүйлгээ хийхээс өмнө хуурамч гүйлгээ хийгдэх гэж байгааг олж тогтоох, уг гүйлгээг хийхгүй байх нь хөрөнгө мөнгө, цаг хугацаагаа алдахаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн залилан, луйврыг багасгахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Үүнээс гадна хувь хүн бүр энэ талаар мэдлэг, мэдээлэлтэй байж, өөрийгөө цахим залилангийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх нь хамгийн чухал юм.

ХЭРХЭН ЦАХИМ

ЗАЛИЛАНД ӨРТӨХӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЖ БОЛОХ ВЭ?



БАТАЛГААЖУУЛ

Сошиал сүлжээнд таны танил санхүүгийн тусламж авахыг хүсвэл эхлээд тухайн хүн мөн эсэхийг баталгаажуулаарай.



НУУЦАЛ

Та өөрийн ашигладаг сошиал сүлжээ, имэйл, банкны аппликэйшний нууц үгээ хүчтэй нууц үг /strong password/ -ээр хамгаалаарай.



БҮҮ АШИГЛУУЛ

Та гуравдагч этгээдэд өөрийн нэр дээр байдаг банкны данс, картаа бүү ашиглуулаарай.



БОЛГООМЖИЛ

Интернетээр худалдан авалт хийхдээ баталгаат онлайн дэлгүүр эсэхийг баталгаажуулсны дараа өөрийн хувийн мэдээллийг оруулаарай.



ТАТГАЛЗ

Гуравдагч этгээдийн төхөөрөмж дээр интернет банкны мэдээллээ оруулахгүй байх, үнэгүй интернет ашиглахаас аль болох татгалзаарай.

1.2.2. Гадаад улсын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцож хамтран ажилласан байдал

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт болох ФАТФ-ын 40 Зөвлөмжийн Зөвлөмж 29, Зөвлөмж 40 болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Санхүүгийн мэдээллийн алба нь гадаад улсын Санхүүгийн мэдээллийн албатай мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэдээлэл солилцож хамтран ажилладаг бөгөөд энэ хүрээнд тус алба нь 2023 онд дараах байдлаар мэдээлэл солилцож хамтран ажиллав (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Гадаад улсын СМА-тай мэдээлэл солилцсон байдал

	2021	2022	2023
СМА-НААС ГАДААДЫН СМА-НД ЯВУУЛСАН ХҮСЭЛТИЙН ТОО /этгээдийн тоогоор/	140	170	223
ГАДААДЫН СМА-НД ЯВУУЛСАН ХҮСЭЛТИЙН ДАГУУ ИРҮҮЛСЭН ХАРИУНЫ ТОО /этгээдийн тоогоор/	165	138	167
ГАДААДЫН СМА-НААС МЭДЭЭЛЭЛ АВАХ ЧИГЛЭЛЭЭР СМА-НД ИРҮҮЛСЭН ХҮСЭЛТИЙН ТОО /этгээдийн тоогоор/	149	148	13
ГАДААДЫН СМА-НААС МЭДЭЭЛЭЛ АВАХ ЧИГЛЭЛЭЭР СМА-НД ИРҮҮЛСЭН ХҮСЭЛТИЙН ДАГУУ ЯВУУЛСАН ХАРИУНЫ ТОО /этгээдийн тоогоор/	129	99	13
ГАДААДЫН СМА-НААС ШИЛЖҮҮЛСЭН МЭДЭЭЛЛИЙН ТОО	17	21	14

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Тайлант онд нийт 223 этгээдтэй холбогдох 30 хүсэлтийг гадаад улсын Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлсэн бөгөөд Бүгд Найрамдах Солонгос Улс, Сингапур, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын засаг захиргааны онцгой бүс Хон Конг, Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон АНУ гэх зэрэг улсууд руу хамгийн их хүсэлтийг хүргүүлжээ.

Санхүүгийн мэдээллийн алба нь Эгмонт бүлгийн гишүүн улс орнуудын СМА-тай мэдээлэл солилцож хамтран ажиллахаас гадна хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан улс орнуудын СМА-тай мөн мэдээлэл солилцож хамтран ажилладаг. 2023 онд шинээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улстай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан гадаад харилцааг өргөжүүлэн ажиллаж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

**ДОТООД БА ГАДААД
ХАМТЫН АЖИЛЛАГАА**

2.1. ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд олон улсын болон дотоодын төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өндөр ач холбогдол үзүүлдэг. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэдэг ба Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн төрийн 19 байгууллагын төлөөллүүд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхээр тогтмол хамтран ажиллаж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл 2023 онд нэг удаа, Хамтын ажиллагааны зөвлөл дөрвөн удаа дараах байдлаар хуралдсан байна.

Зураг 2. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРЭГ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22¹-1-т заасны дагуу Үндэсний зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд Санхүүгийн мэдээллийн алба нь Үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

1. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, стратеги бүхий хөтөлбөрийн төслийг боловсруулах;
2. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, түүний биелэлтийг үнэлэх, дараагийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах;
3. Зөвлөлийн даргаар дамжуулан Үндэсний хөтөлбөрийн төслийг эрх бүхий байгууллагад хүргүүлж, батлуулах арга хэмжээг авах;
4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаарх шийдвэрийг хурлаар хэлэлцэн гаргах;
5. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг зөвлөл жил бүр дүгнэж, Засгийн газарт хүргүүлэх;
6. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах.

Санхүүгийн мэдээллийн алба 2023 онд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн хуралдааныг 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан ба Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.



2023

05 дугаар
сарын 18

Байгууллагуудын чиг үүрэгт МУТСТ асуудлыг тусгахтай холбоотойгоор байгууллагуудаас гаргасан саналыг нэгтгэн, зөвлөмж хүргүүлэхээр болов.

Үндэсний зөвлөлийн даргын тушаалаар “Зэрлэг ан амьтдын хууль бус худалдаа, хүрээлэн буй орчин, уул уурхайтай холбоотой мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийг судалж, холбогдох арга хэмжээг авах”, “Хуулийн этгээдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд ашиглахтай холбоотой эрсдэлийн үнэлгээг шинэчлэх” болон “Корреспондент банк, цахим шилжүүлэг болон гуравдагч этгээдийг ашиглахтай холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор санхүүгийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоог хөгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг нэвтрүүлэх болон мэдээлэх үүрэгтэй этгээд мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан түвшинд харилцагчийн мэдээллийг өөр хоорондоо хуваалцах замаар харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гүйцэтгэх боломжийг судлах” чиг үүрэг бүхий ажлын хэсгүүдийг байгуулав.

Зураг 3. Хамтын ажиллагааны зөвлөлийн бүрэлдэхүүн



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22.3-т заасны дагуу Санхүүгийн мэдээллийн алба нь Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэдэг. Хамтын ажиллагааны зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд:

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох зөвлөмж, санал гаргах;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг Монгол Улсын хэмжээнд судлах, эрсдэлийн үнэлгээ хийх, үр дүнг тооцох ажиллагааг тогтмол зохион байгуулах;

- Үндэсний эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, үр дүнтэй, оновчтой зохион байгуулах талаар зөвлөмж гаргах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нөхцөл байдал, үр дүнгийн талаар мэдээлэл солилцох;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагын үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэхтэй танилцаж мөрдүүлэх талаар санал, зөвлөмж гаргах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан дүрэм, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний болон Хамтын ажиллагааны зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих, гүйцэтгэлийн явцтай танилцах, шаардлагатай бол хэрэгжилтийг хангаж ажиллахыг шаардах, гүйцэтгэлийг Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэх, хугацаатай үүрэг даалгавар өгөх, үйл ажиллагааны уялдаа холбоог хангуулах зэрэг холбогдох арга хэмжээг авах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг олон улсын стандарт, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 Зөвлөмжид нийцүүлэх талаар санал гарган танилцуулах;
- Гишүүн байгууллагын үйл ажиллагааг үндэсний болон бүс нутаг, олон улсын байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажилтай уялдуулахад дэмжлэг үзүүлэх;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэгдэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, хувийн хэвшил болон олон нийтэд зориулсан сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх талаар өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх;
- Санхүүгийн мэдээллийн албаны бүтэц, зохион байгуулалт, төсөв, үйл ажиллагааны зардлын талаар санал гаргах, танилцуулах, шийдвэрлүүлэх;
- Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх Ажлын хэсгийн хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй танилцах, хэрэгжүүлэх санал зөвлөмж, хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах;
- Хамтын ажиллагааны зөвлөлийн гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих.

Монголбанкны ерөнхийлөгчийн 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А-229 тушаалын дагуу Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэд дараах 6 ажлын хэсэг ажиллаж байна.

Зураг 4. Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх дэд ажлын хэсгүүд



Хамтын ажиллагааны зөвлөл нь

2023
ОНД

1 дүгээр сарын 30,
4 дүгээр сарын 14,
9 дүгээр сарын 08,
12 дугаар сарын 26-ны өдөр

тус тус хуралдаж, дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

1/30

- Үндэсний хөтөлбөрийн ажлын төлөвлөгөөн дэх ХАЗ-ийн ажлуудыг байгууллага бүрд хуваарилахаар болов.
- Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2023 оны Явцын тайланг 2024 оны 02 дугаар сарын 01-нд хүргүүлэхээр болов.
- Зайнаас харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг ФАТФ-ийн зөвлөмжтэй уялдуулан нэвтрүүлэх, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд ХАЗ-ын гишүүд дэмжин ажиллахаар болов.

4/14

- Зайнаас харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаатай холбоотой судалгааг Судалгаа дүн шинжилгээ, Хууль, эрх зүйн орчныг сайжруулах ажлын хэсэг хамтран гүйцэтгэхээр шийдвэрлэв.
- Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг хэсгийг хуралдуулж, эрсдэлийн үнэлгээг эцэслэх, зохион байгуулалтын ажлыг Санхүүгийн мэдээллийн алба хийхээр үүрэг болгов.
- Хамтын ажиллагааны зөвлөлийн журамд өөрчлөлт оруулах саналыг гишүүдийн олонх дэмжив.

9/08

- Хууль сахиулах ажлын хэсэг болон Хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хэсгүүд хуралдаж, ажлын хэсгийн төлөвлөгөө, гишүүдийн нэрсийг албан бичгээр ирүүлэхээр болов.
- Терроризмтой тэмцэх зөвлөл үндэсний эрсдэлийн үнэлгээний эцэслэсэн хувилбарыг Санхүүгийн мэдээллийн алба болон Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2023 оны 9 дүгээр сарын 15-ны дотор хүргүүлэхээр болов.

12/26

- Хууль эрх зүйн орчныг сайжруулах ажлын хэсгээс МУТС, ҮОХЗДСТ үйл ажиллагааг хариуцан ажиллах хүний нөөц, орон тоо нэмэгдүүлэх, хавсран гүйцэтгэж буй албан хаагчдад нэмэгдэл олгох талаар холбогдох хууль тогтоомжийг судалж танилцуулахаар болов.
- Монгол Улсын 2024 оны Явцын тайланд ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах болон ФАТФ-ын Зөвлөмжид орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг тусган, 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор АНДМУТБ-т хүргүүлэхээр болов.


2.2. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

2.2.1. Харилцан ойлголцлын санамж бичиг

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулснаар санамж бичиг байгуулж буй хоёр улсын Санхүүгийн мэдээллийн алба харилцан сонирхол болон хамтран ажиллах чин эрмэлзлэлийн үндсэн дээр хоёр улсын хууль тогтоомжийн хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэдээлэл солилцож хамтран ажиллах, харилцан туслалцаа дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой юм.

Санхүүгийн мэдээллийн алба нь 2023 оны байдлаар нийт 23 орны Санхүүгийн мэдээллийн албатай мэдээлэл солилцож хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна.

Зураг 5. Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан улс орнууд



Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан хамгийн сүүлийн орон болох Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макаогийн Санхүүгийн мэдээллийн албатай байгуулсан санамж бичгийг Канад Улсын Ванкувер хотноо 2023 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 25 дахь удаагийн жилийн уулзалтын үеэр солилцов.

Зураг 6. Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макаогийн Санхүүгийн мэдээллийн албатай санамж бичиг солилцов.



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Зураг 7. Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Санхүүгийн мэдээллийн албатай санамж бичиг солилцов.



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Түүнчлэн Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Санхүүгийн мэдээллийн албатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох зорилгоор хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 29-нөөс 02 дугаар сарын 02-ны өдрүүдэд Мальта Улсын Сент Жулианс хотноо зохион байгуулагдсан зохион Эгмонт бүлгийн бүс нутгийн болон ажлын хэсгийн чуулга уулзалтын үеэр хоёр улсын Санхүүгийн мэдээллийн албаны дарга нар Хамтын ажиллагааны санамж бичгийг албан ёсоор солилцлоо.


2.2.2. Олон улсын хамтын ажиллагаа /ФАТФ, АНДМУТБ, ЕАМУТБ, Эгмонт бүлэг/

САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА (ФАТФ)

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, дэлхийн санхүүгийн системийг хамгаалах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газар хоорондын хараат бус байгууллага юм. ФАТФ-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улс тогтмол идэвх зүтгэл гарган ажиллаж байна. Тухайлбал, Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ-ын 2023 онд зохион байгуулсан чуулга уулзалтуудад оролцов. Энэхүү чуулга уулзалтад оролцсоноор олон улсын нөхцөл байдал, чиг хандлагад үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ФАТФ-аас гаргаж буй шинэ зохицуулалт, зөвлөмж, стандартын талаарх мэдээллийг авснаас гадна ФАТФ-ын шинэчилсэн аргачлалын дагуу хийгдэх дараагийн шатны харилцан үнэлгээ нь Монгол Улсад хэрхэн нөлөөлөх талаар судалж, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх чухал ач холбогдолтой.

АЗИ, НОМХОН ДАЛАЙН МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ БҮЛЭГ

ФАТФ-ын төрлийн, бүс нутгийн хэмжээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэг бүхий Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг нь 1997 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улс 2004 онд гишүүнээр элссэн.



ФАТФ-ын бүс нутгийн байгууллагуудаас гишүүн улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлж, харилцан үнэлгээний тайлан гаргадаг. Харилцан үнэлгээгээр ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилт болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлдэг.

Монгол Улсаас ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулах Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлсэн. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 2023 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан жилийн чуулга уулзалтаар Монгол Улсын 2023 оны Явцын тайланг хэлэлцэж, Зөвлөмж 8-ын үнэлгээг “Бүрэн биелүүлсэн” болгож ахиулахаар шийдвэрлэсэн. Улмаар 2023 оны 10 дугаар сард Монгол улсын Явцын тайланг олон нийтэд нийтэлсэн¹.

Үүнээс гадна Санхүүгийн мэдээллийн албанаас Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс зохион байгуулдаг сургалтад хамрагдах, бусад улс орнуудын тайлантай танилцаж, санал өгөх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой ирүүлсэн асуулга бөглөх, сайн туршлага, типологи, бодит жишээг хуваалцах, шаардлагатай бусад мэдээллийг хүргүүлэх байдлаар тогтмол хамтарч ажиллаж байна. Тухайлбал, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2023 онд дэлхийн улс орнуудын шинэ технологитой холбоотой Зөвлөмж 15-ын хэрэгжилтийг сайжруулах ажлуудыг идэвхтэй зохион байгуулж ажиллав. Энэ хүрээнд Монгол Улсын туршлагыг сайн жишигт тооцож, туршлага хуваалцахыг хүссэн. Улмаар Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо хамтран 2023 оны 5 дугаар сард Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн уулзалт дээр виртуал хөрөнгийн салбарт хийсэн эрсдэлийн үнэлгээний талаар илтгэл танилцуулсан. Тус бүлгийн 2023 оны 12 дугаар сард зохион

¹ <https://www.fatf-gafi.org/en/publications/Mutualevaluations/fur-mongolia-2023.html>

байгуулсан Типологийн жилийн уулзалтаар Монгол Улсын туршлагыг танилцуулан, панель хэлэлцүүлэгт оролцсон. Түүнчлэн Латви улсын Санхүүгийн мэдээллийн албанаас Рига хотод 2023 оны 5-р сарын 18-ны өдөр зохион байгуулсан крипто хөрөнгийн бага хуралд Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл цахимаар оролцон, Монгол улс дахь виртуал хөрөнгийн зохицуулалтын орчны талаар туршлага хуваалцав. Эдгээр арга хэмжээ нь Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо олон улсын стандартад нийцэж, бусад улс орнууд манай улсын туршлагаас суралцаж буйг илтгэж байна.

ЕВРО-АЗИЙН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ БҮЛЭГ

Монгол Улс 2012 оны 5 дугаар сард Евро-Азийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүлгийн ажиглагч улсаар нэгдсэн ба тус бүлгийн гишүүн болон бусад ажиглагч улс орнуудтай мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэдээлэл солилцоог сайжруулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Тухайлбал, Санхүүгийн мэдээллийн албанаас 2023 оны 5 дугаар сард Монгол Улсын ажиглагчийн үйл ажиллагааны тайланг боловсруулж хүргүүлсэн. Евро-Азийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүлгийн 2023 оны 6 дугаар сарын 04-ний өдрөөс 09-ний өдрүүдэд зохион байгуулсан 38 дахь чуулга уулзалтад Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газрын төлөөллүүд тус тус оролцов.

ЭГМОНТ БҮЛГИЙН УУЛЗАЛТ

Дэлхийн 170 орны Санхүүгийн мэдээллийн албадын олон улсын нийгэмлэг болох Эгмонт бүлэгт Монгол Улс 2009 онд гишүүнээр элссэн. Эгмонт бүлэг нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор өөрийн гишүүн улс орны Санхүүгийн мэдээллийн албадын үйл ажиллагаа болон мэдээлэл солилцох чадавхыг бэхжүүлэх, туршлага судлах, техник туслалцаа үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, ФАТФ-ын Зөвлөмж 29-д заасны дагуу Эгмонт бүлгээс баталсан “Санхүүгийн мэдээллийн алба хоорондын мэдээлэл солилцох үндсэн зарчим”-ын хүрээнд Эгмонт бүлгийн гишүүн орнуудын Санхүүгийн мэдээллийн албадтай болон хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан нийт 23 орны гадаад улсын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

2.2.3. Олон улсын хамтын ажиллагаа /олон улсын донор байгууллагууд/

Санхүүгийн мэдээллийн алба нь олон улсын донор байгууллагуудтай техник туслалцааны хүрээнд идэвхтэй хамтран ажилладаг. 2023 онд Дэлхийн банкны Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл, АНУ-ын Сангийн яамны Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр техник туслалцааны төсөл, мөн Санхүүгийн үйлчилгээний сайн дурын корпусаас Монгол Улсын санхүүгийн салбарын корреспондент харилцааг бэхжүүлэх чиглэлээр техник туслалцааны төслүүдийн хүрээнд хамтран ажиллав.

ДЭЛХИЙН БАНК

Дэлхийн банкны Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн хүрээнд олон улсын зөвлөхүүдтэй хамтран Монгол Улсын Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилан

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийн төслийг улс орнуудын сайн туршлагад үндэслэн боловсруулсан. Улмаар Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 265 дугаар тогтоолоор үндэсний хэмжээнд хэрэгжих “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг баталсан. Цаашлаад уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 тоот тушаалаар баталсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх, дараагийн шатны харилцан үнэлгээгээр амжилттай дүн авах, олон улсын байгууллагын хориг жагсаалтад орохгүй байх ач холбогдолтой юм.

Түүнчлэн төслийн санхүүжилтээр банкуудын хил дамнасан гадаад корреспондент банкны харилцааг сайжруулах чиглэлээр судалгааны ажлыг хийж гүйцэтгэх дотоодын зөвлөх багийг сонгон шалгаруулж, “Монгол Улсын банкуудын корреспондент харилцааг сайжруулахад тулгамдаж буй асуудлууд” сэдэвт судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Санхүүгийн мэдээллийн албанаас Монголын банкны холбоо, арилжааны банкны комплаенсийн албан хаагчид, Дотоод хэргийн их сургуулийн төлөөллүүдийг оролцуулан 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр тус судалгааны хэлэлцүүлгийг зохион байгуулж, ирүүлсэн саналыг судалгааны тайланд тусган эцэслэв.

САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЙН ДУРЫН КОРПУС

АНУ-ын Санхүүгийн үйлчилгээний сайн дурын корпусын зөвлөхүүд Монгол Улсын арилжааны банкууд болон АНУ, барууны бусад улс орнуудын санхүүгийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, корреспондент банкны харилцаа тогтоох боломжийг бүрдүүлэх, олон улсын шаардлагад нийцүүлэхэд чиглэсэн 3 өдрийн сургалтыг Санхүүгийн мэдээллийн албатай хамтран 2023 оны 9 дүгээр сард зохион байгуулсан. Сургалтын дараа зөвлөхүүд арилжааны банкуудын төлөөллүүдтэй ганцаарчилсан уулзалт хийв. Энэхүү сургалт, уулзалтаар корреспондент банкны харилцаанд анхаарах асуудлууд, газар зүйн эрсдэлийн хүчин зүйлс, харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ, гүйлгээтэй холбоотой эрсдэлийн талаар хэлэлцэж, туршлага судалсан.

Монгол улс 2019 оны 10 сард ФАТФ-ын “Саарал жагсаалт”-д орсноос хойш АНУ-д төвтэй банкуудтай шууд харилцаагүй болж, өнгөрсөн хугацаанд ихэнх банкуудын гадаад төлбөр тооцоо гуравдагч банкаар дамжиж байсан. Монгол Улсын корреспондент харилцааг бэхжүүлэх хүрээнд гадаад болон төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улсын арилжааны банк 2023 онд АНУ-ын Нью-Йорк Меллон банктай корреспондент банкны харилцааг амжилттай тогтоож, ам.долларын ностро данстай болсон. Ингэснээр гадаад төлбөр тооцоог түргэн шуурхай хийх, шилжүүлэг хийх зардал буурах боломж бүрдээд байна.

АНУ-ЫН САНГИЙН ЯАМ

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр техник туслалцааны төслийн хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд заасан мэдээлэл хүлээж авах үйл ажиллагаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, улмаар бүх мэдээлэл үүрэгтэй этгээдэд зориулсан нэгдсэн порталтай болох зорилгоор НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар (UNODC)-аас хөгжүүлсэн, гоАМЛ программыг АНУ-ын Сангийн яамны техник туслалцаатайгаар үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.


Мөн АНУ-ын Сангийн яамны зөвлөхүүд 2023 оны туршид Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах чиглэлээр төр, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллүүдэд шаардлагатай сэдвээр сургалт, уулзалтуудыг зохион байгуулж, чадавхыг бэхжүүлэх

ажилд дэмжлэг үзүүлэн ажилласан. Тухайлбал, ФАТФ-ын Зөвлөмж 8-ын техник хэрэгжилтийг сайжруулах ажлын хүрээнд АНУ-ын Сангийн яамны зөвлөх эрх бүхий байгууллагуудын албан тушаалтнуудад зориулсан “Ашгийн бус байгууллагуудыг терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь” болон “Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ялангуяа ашгийн бус байгууллагыг терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашиглах эрсдэлийг бууруулах нь” сэдэвт сургалтуудыг 2023 оны 01 дүгээр сард зохион байгуулсан. Мөн Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс АНУ-ын Сангийн яамны зөвлөхтэй хамтран 2023 оны 12 дугаар сард “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх” сэдвээр их, дээд сургуулиудын сургагч багш нар болон мэргэжлийн холбоодын нийт 20 гаруй төлөөллүүдэд сургалтад хамруулав. Түүнчлэн хянан шалгах чиг үүрэг бүхий мэргэжлийн холбоодын комплаенс хариуцсан ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх, хууль сахиулах байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалтууд зохион байгууллаа.

Зураг 8. АНУ-ын Сангийн яамны зөвлөхтэй хамтарсан сургалт



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба



ГУРАВДУГААР БҮЛЭГ

**ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙН
ТЕХНИК ХЭРЭГЖИЛТИЙН
ҮНЭЛГЭЭ**

Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт болох 40 Зөвлөмжийн хэрэгжилтийн талаар жил бүр тайлагнах үүрэгтэй.

Энэ хүрээнд Монгол Улсын 2023 оны Явцын тайланг бэлтгэн хүргүүлэх талаар Хамтын ажиллагааны зөвлөл болон Үндэсний зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцэж, ФАТФ-ын Зөвлөмж 8-ын техник хэрэгжилтийн үнэлгээг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлж, тайланг бэлтгэж хамгаалах Ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэсэн. Ажлын хэсгийг Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/379 дүгээр тушаалаар байгуулсан. Санхүүгийн мэдээллийн албанаас ажлын хэсгийг ахалж, дэд ахлагчаар Хууль зүй, дотоод хэргийн яам болон Тагнуулын ерөнхий газраас төлөөлж ажилласан. Ажлын хэсгийн гишүүдээр Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн газраас төлөөлөл орж ажилласан.

Зураг 9. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 25 дахь удаагийн Жилийн уулзалт



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Ажлын хэсгийн зүгээс ФАТФ-ын Зөвлөмж 8-ын 6 шалгуур үзүүлэлт тус бүрийн хувьд тайлагнах арга хэмжээг багтаасан ажлын төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр баталж хэрэгжүүлсэн бөгөөд нийт 6 удаагийн хурлаар тайлангийн төслийг хэлэлцсэн. Улмаар Монгол Улсын 2023 оны Явцын тайлангийн төслийг Хамтын ажиллагааны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, санал авснаас гадна АНУ-ын Сангийн яамны зөвлөхөөс санал авч, эцэслэсэн. Улмаар Монгол Улсын 2023 оны Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс ирүүлсэн загварын дагуу боловсруулж, 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлээ.

Монгол Улсын 2023 оны Явцын тайлан нь үндсэн 2 хэсгээс бүрдсэн бөгөөд тайлангийн эхний хэсэгт 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх 1 жилийн хугацаанд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан голлох ахиц дэвшил, улс төрийн өндөр түвшний оролцоог дурдсан бөгөөд Монгол Улсын тогтолцоонд гарсан өөрчлөлт, сайжруулалтуудын талаарх мэдээллийг дурдсан. Харин техник хэрэгжилтийн талаарх дүн шинжилгээний хэсэгт ФАТФ-ын Зөвлөмж 8-д заасны дагуу ашгийн бус байгууллагыг терроризмыг санхүүжүүлэхэд ашиглах эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, холбогдох хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зэрэг чиглэлээр хийж гүйцэтгэсэн дараах ажлуудыг тайлагнасан. Үүнд:



Ашгийн бус байгууллагын терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ахалсан ажлын хэсэг хийж гүйцэтгэсэн.



Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэд Ашгийн бус байгууллагыг терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажилласан.



Ашгийн бус байгууллагад зориулсан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон хамгаалах тухай зөвлөмжийг боловсруулж, Монголбанк болон холбогдох бусад эрх бүхий байгууллагуудын цахим хуудсанд байршуулсан.



Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудтай хамтран ашгийн бус байгууллагуудыг

терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр **2022** онд нийт **7** сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал, АНУ-ын Сангийн яамны зөвлөхүүдтэй хамтарсан **2023** оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн сургалтад Монголбанк дээр төрийн байгууллагууд болон ашгийн бус байгууллагын **70** гаруй төлөөллийг хамруулан зохион байгуулсан. Мөн **2023** оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хууль сахиулах байгууллагын **90** гаруй прокурор, мөрдөгч нарт зориулсан цахим сургалтыг Санхүүгийн мэдээллийн албанаас явуулсан.



Санхүүгийн мэдээллийн албанаас Терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх тухай гарын авлагыг боловсруулж, цахим хуудсанд нийтэлснээс гадна Сэжигтэй гүйлгээний эрсдэлийн үнэлгээ хийх гарын авлагыг боловсруулсан.



Терроризмтой тэмцэх зөвлөлөөс FATF-ын "Ашгийн бус байгууллагуудыг зүй бусаар ашиглахтай тэмцэх нь: Сайн туршлагын гарын

авлага" болон "Ашгийн бус байгууллагыг терроризмын зорилгоор хууль бусаар ашиглах эрсдэл" сэдэвт гарын авлагыг орчуулан Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд байршуулсан.



Монголбанкнаас ашгийн бус байгууллагуудтай холбоотой банкуудад газар дээрх сэдэвчилсэн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд ашгийн бус байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй холбоотой санхүүгийн байгууллагуудад зориулсан зааврыг боловсруулж цахим хуудсанд байршуулсан.



Санхүүгийн зохицуулах хорооноос зайны хяналтын асуулгад ашгийн бус байгууллагатай холбоотой асуултуудыг нэмж оруулан цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн байгууллагуудаас судалгаа авч нэгтгэсэн.



Татварын ерөнхий газрын даргын **2022** оны 6 дугаар сарын 24-ны өдрийн А/70 дугаар тушаалаар батлагдсан **"Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам"**-д төрийн бус байгууллагын татварын ногдуулалт, төлөлтийн байдалд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх тохиолдолд татварын байгууллагаас баталсан зааврыг мөрдөхөөр тусгасан бөгөөд тус зааврыг **Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулж, татварын албанд хүргүүлсэн.**

Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ашгийн бус байгууллагуудад хийж буй хяналт шалгалтын талаарх мэдээллийг тусгасан.



Тагнуулын ерөнхий газраас ашгийн бус байгууллагын чиглэлээр эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо, мөрдөн шалгалт, олон улсын мэдээлэл солилцох хүсэлтэд хариу өгөх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгасан.

Зураг 10. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 25 дахь удаагийн Жилийн уулзалт



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Монгол Улсын 2023 оны Явцын тайлантай холбоотойгоор Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн үнэлгээний багаас нэмэлт тайлбар, мэдээлэл авах хүсэлтийг ирүүлсний дагуу 2023 оны 3 дугаар сараас 7 дугаар сарын хооронд холбогдох хариу тайлбарыг тухай бүр хүргүүлж ажиллав. Улмаар 2023 оны 6 дугаар сард Монгол Улсын Явцын тайланд Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүдээс 2 долоо хоногийн хугацаанд санал авсан бөгөөд ФАТФ-аас нэмэлт тодруулга хүссэний дагуу мэдээллийг хүргүүлсэн.

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 25 дахь удаагийн Жилийн уулзалт Канад Улсын Ванкувер хотноо 2023 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан. Тус чуулга уулзалтаар Монгол Улсын 6 дахь удаагийн буюу 2023 оны Явцын тайланг хэлэлцсэн бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр голлох хийж гүйцэтгэсэн арга хэмжээ, гаргасан ахиц дэвшлийн талаар үг хэлж оролцов.

Монгол Улсын 2023 оны Явцын тайланг хамгаалах ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд ахалж, Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газрын төлөөллүүд оролцсон.

Энэ удаагийн жилийн уулзалтаар ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн шаардлагын дагуу Монгол Улсын 2023 оны Явцын тайланг хэлэлцэж, баталсан. Үүний дүнд ашгийн бус байгууллагатай холбоотой ФАТФ-ын Зөвлөмж 8-ын үнэлгээг “Бүрэн биелүүлсэн” болгож амжилттай ахиулав. Жилийн уулзалтын үеэр ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Евро-Азийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх болон ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийг хангах чиглэлээр гаргасан ахиц дэвшилд баяр хүргэж, үг хэлэв.

Монгол Улсын хувьд Явцын тайлангийн үр дүнд ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийг бүрэн биелүүлсэн үнэлгээтэй Ази, Номхон далайн орнуудаас анхны орон (Зөвлөмж 15-ыг шинэчилсэн үнэлгээгээр), дэлхийн улсуудаас 5 дахь орон болсон. Энэ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт болох ФАТФ-ын 40 Зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улс шаардлагатай хууль эрх зүй, зохицуулалтын орчинг бий болгон ажиллаж байгааг олон улсаас баталгаажуулж буй явдал боллоо.

ФАТФ-ын Зөвлөмж тус бүрийн техник хэрэгжилтийн үнэлгээ (Хүснэгт 10) болон үнэлгээний хуваарилалт (Зураг 12) дараах байдалтай байна. Үүнд:




Бүрэн биелүүлсэн: C-COMPLIANT,
Дийлэнхийг биелүүлсэн: LC-LARGELY COMPLIANT,
Хэсэгчлэн биелүүлсэн: PC-PARTIALLY COMPLIANT,
Биелүүлээгүй: NC-NONCOMPLIANT


Хүснэгт 10. Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн үнэлгээ

Зөвлөмж 1- Эрсдэлээ үнэлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх	Зөвлөмж 2- Үндэсний хамтын ажиллагаа болон уялдаа холбоо	Зөвлөмж 3- Мөнгө угаах гэмт хэрэг	Зөвлөмж 4- Хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ	Зөвлөмж 5- Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг
LC	LC	LC	LC	LC
Зөвлөмж 6- Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ	Зөвлөмж 7- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ	Зөвлөмж 8- Ашгийн бус байгууллага	Зөвлөмж 9- Санхүүгийн байгууллагын нууцлалын хууль тогтоомж	Зөвлөмж 10- Харилцагчийг таньж мэдэх
LC	LC	C	LC	LC
Зөвлөмж 11- Баримт материал хадгалах	Зөвлөмж 12- Улс төрд нөлөө бүхий этгээд	Зөвлөмж 13- Корреспондент банкны үйл ажиллагаа	Зөвлөмж 14- Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ	Зөвлөмж 15- Шинэ технологи
C	LC	LC	C	LC
Зөвлөмж 16- Цахим шилжүүлэг	Зөвлөмж 17- Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх	Зөвлөмж 18- Дотоод хяналт болон гадаадад хяналт салбар, охин компани	Зөвлөмж 19- Өндөр эрсдэлтэй улс орнууд	Зөвлөмж 20- Сэжигтэй гүйлгээг мэдээлэх
LC	LC	LC	LC	LC
Зөвлөмж 21- Мэдээллийг задруулах болон нууцлал	Зөвлөмж 22- СББМҮҮ: Харилцагчийг таньж мэдэх	Зөвлөмж 23- СББМҮҮ: Бусад арга хэмжээ	Зөвлөмж 24- Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал	Зөвлөмж 25- Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч
C	LC	LC	LC	LC
Зөвлөмж 26- Санхүүгийн байгууллагын зохицуулалт, хяналт шалгалт	Зөвлөмж 27- Хянан шалгагчын эрх мэдэл	Зөвлөмж 28- СББМҮҮ-ийн зохицуулалт, хянан шалгалт	Зөвлөмж 29- Санхүүгийн мэдээллийн алба	Зөвлөмж 30- Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын үүрэг
LC	LC	LC	C	C
Зөвлөмж 31- Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын эрх мэдэл	Зөвлөмж 32- Бэлэн мөнгө зөөвөрлөгчид	Зөвлөмж 33- Статистик мэдээлэл	Зөвлөмж 34- Зааварчилгаа, эргэх холбоо	Зөвлөмж 35- Шийтгэлийн арга хэмжээ
C	LC	LC	LC	LC
Зөвлөмж 36- Олон улсын арга хэрэгслүүд	Зөвлөмж 37- Эрх зүйн харилцан туслалцаа	Зөвлөмж 38- Эрх зүйн харилцан туслалцаа: хөрөнгө царцаах, хураах	Зөвлөмж 39- Гэмт хэрэгтэн шилжүүлэх	Зөвлөмж 40- Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр
C	C	LC	LC	LC

Зураг 11. Монгол Улсын 2023 оны Явцын тайлан



Зураг 12. Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн үнэлгээний хуваарилалт



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба



-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИК ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЦАГ ХУГАЦААНЫ ДАРААЛАЛ

2022.12.30

ФАТФ-ын Зөвлөмж 8-ын техник хэрэгжилтийн үнэлгээг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлж, тайланг бэлтгэж хамгаалах Ажлын хэсгийг Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/379 дүгээр тушаалаар байгуулав.

2023.01.03

Ажлын хэсгийн хурлаар ФАТФ-ын Зөвлөмж 8-ын 6 шалгуур үзүүлэлт тус бүрийн хувьд тайлагнах арга хэмжээг багтаасан ажлын

төлөвлөгөөг хэлэлцэж, 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлав.

2023.01.13

Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба болон холбогдох байгууллагуудаас АНУ-ын Сангийн яамны зөвлөхүүдтэй хамтран ашгийн бус байгууллагуудыг терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх сургалтыг 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Монголбанк дээр төрийн байгууллагууд болон ашгийн бус байгууллагын 70 гаруй төлөөллийг хамруулан зохион байгуулав.

2023.01.16

ФАТФ-ын Зөвлөмж 8-ын техник хэрэгжилтийн үнэлгээг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж, тайланг бэлтгэж хамгаалах ажлын хэсгийн төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэж, тайланг боловсруулахад шаардлагатай тайлбар, мэдээллийг нэгтгэх зорилгоор ажлын хэсэг 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр цахимаар хуралдав.

2023.01.17

Ажлын хэсгийн хурлыг 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж, “Татварын хяналт шалгалтад хамрагдах ашгийн бус байгууллагыг сонгох, хяналт шалгалт хийх заавар”-ын төслийг боловсруулан санал авч ажиллав.

2023.01.19

Ажлын хэсгээс “Ашгийн бус байгууллагын терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлын хэсэг” байгуулах санал гаргасан бөгөөд ажлын хэсгийн 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн хурлаар хэлэлцэж дэмжсэн.

2023.01.20

Санхүүгийн мэдээллийн албанаас АНУ-ын Сангийн яамны зөвлөхүүдтэй хамтран 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хууль сахиулах байгууллагуудын 90 гаруй прокурор, мөрдөгч нарт зориулсан цахим сургалтыг явуулсан. Түүнчлэн, ажлын хэсгээс хуралдаж, батлагдсан төлөвлөгөөний дагуу Зөвлөмж 8-ын тайланг боловсруулахад шаардлагатай тайлбар мэдээллийг хэлэлцэв.

2023.01.30

Монгол Улсын 2023 оны Явцын тайлангийн төслийг Хамтын ажиллагааны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, санал авснаас гадна АНУ-ын Сангийн яамны зөвлөхөөс санал авч, эцэслэсэн.

2023.02.01

Монгол Улсын 2023 оны Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс ирүүлсэн загварын дагуу эцэслэн боловсруулж, 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлэв.

2023.03.15

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн үнэлгээний багаас 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Явцын тайлантай холбоотойгоор нэмэлт тайлбар, мэдээллийг ирүүлэхийг хүссэн.

2023.03.22

Ажлын хэсгийн хурлыг 2023 оны 3 дугаар сарын 16, 20-22-ны өдрүүдэд нийт 4 удаа зохион байгуулж, нэмэлт тайлбар, мэдээллийг 4 хавсралтын хамт бэлтгэн 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлсэн.

2023.05.24

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн багаас Монгол Улсын 2023 оны Явцын тайланд өгсөн үнэлгээ, дүгнэлтийн төслийг 2023 оны 5 дугаар сарын 24-ны өдөр ирүүлсэн.

2023.05.29

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн өгсөн үнэлгээ, дүгнэлттэй танилцаж, Зөвлөмж 8-ийн үнэлгээг “Бүрэн биелүүлсэн” болгож ахиулахаар болсон явдалд талархал илэрхийлсэн.

2023.06.01

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын 2023 оны Явцын тайланд тус бүлгийн гишүүн улс орнууд, байгууллагуудаас санал авах тул тайлантай холбоотой санал ирүүлэхийг хүссэн.

2023.06.02

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуралдаж, Монгол Улсын 2023 оны Явцын тайланд тусгах саналууд болон нэмэлт тайлбар мэдээллийг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлэв.

2023.06.05

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын 2023 оны Явцын тайланд холбогдох саналыг тусган, тус бүлгийн гишүүн улс орнууд, байгууллагуудаас 2 долоо хоногийн хугацаанд санал авахаар хүргүүлсэн.

2023.06.19

Монгол Улсын 2023 оны Явцын тайлантай тус бүлгийн гишүүн улс орнууд, байгууллагууд танилцаж, ФАТФ-аас нэмэлт тайлбар авахыг хүссэн талаар Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс мэдээлсэн.

2023.06.23

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуралдаж, Монгол Улсын 2023 оны Явцын тайланд ФАТФ-аас хүссэн нэмэлт тайлбарын хариуг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлсэн.

2023.06.30

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын 2023 оны Явцын тайланд хүргүүлсэн саналыг тусган эцэслэж, 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр цахим портал хуудсандаа байршуулав.

2023.07.04

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын 2023 оны Явцын тайлантай холбоотой ФАТФ-ын нэмэлт тайлбарын хариу, тодруулгын талаарх мэдээллийг цахим портал хуудсандаа оруулсан.

2023.07.10

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 2023 оны 7 дугаар сарын 9-14-ний өдрүүдэд Канад Улсын Ванкувер хотод зохион байгуулагдсан. Тус жилийн уулзалт үеэр болсон Харилцан үнэлгээний хорооны хурлаар Монгол Улсын 2023 оны Явцын тайланг хэлэлцсэн. Тус хуралд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд хурал дээр голлох хийж гүйцэтгэсэн арга хэмжээ, гаргасан ахиц дэвшлийн талаар үг хэлж оролцов.

2023.07.12

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Харилцан үнэлгээний хорооноос Монгол Улсын 2023 оны Явцын тайланг хэлэлцсэн талаарх тайланг цахим портал хуудсандаа нийтэлсэн. Улмаар тус бүлгийн 2023 жилийн уулзалтаар Монгол Улсын 2023 оны Явцын тайланг хэлэлцэж баталсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд үг хэлж оролцов. ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Евро-Азийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх болон ФАТФ-ын 40 Зөвлөмжийг техник хэрэгжилтийг хангах чиглэлээр гаргасан ахиц дэвшилд баяр хүргэж, үг хэлэв.

2023.07.18

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын 2023 оны Явцын тайлантай холбоотой санал, дүгнэлтүүдийг эцсийн байдлаар хянах хүсэлтийг ирүүлсэн.

2023.07.31

Монгол Улсын 2023 оны Явцын тайланг эцэслэх хүрээнд холбогдох үг үсгийн алдаа, эцсийн засваруудыг оруулан Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлэв.

2023.10.19

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын 2023 оны Явцын тайланг эцэслэн, тус бүлгийн гишүүдэд зориулан цахим портал хуудсандаа байршуулав.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

**ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ,
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГАА**

4.1. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН СУРГАЛТ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон улсын байгууллагуудаас зохион байгуулсан сургалт семинар, конференц, форумд идэвхтэй оролцох нь Монгол Улсыг төлөөлж, олон улсын хэмжээнд байр суурийг илэрхийлэх, холбогдох тайланг хамгаалах, олон улсын нөхцөл байдал, чиг хандлагад үндэслэн дэлхийн хэмжээнд гаргаж буй шинэ зохицуулалт, зөвлөмж, стандартын талаарх мэдээллийг шууд авах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг ач холбогдолтой юм. Санхүүгийн мэдээллийн албанаас 2023 онд ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Евро-Азийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүлэг болон бусад олон улсын байгууллагуудаас зохион байгуулсан сургалт, хурал, форум, вэбинарт идэвхтэй оролцож, тус уулзалт сургалтыг Монгол Улсад зохион байгуулахад хамтран ажиллаа. Нийт 15 гаруй сургалтад Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл болон хувийн хэвшлийн давхардсан тоогоор 1031 орчим төлөөллийг хамруулав. Доорх хүснэгтэд дэлгэрэнгүй тусгав.

Хүснэгт 11. Олон улсын байгууллагуудаас зохион байгуулсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлээр сургалт, конференц, форум, вэбинарын жагсаалт



- АНУ-ын Хууль зүйн яамны Прокурорын хөгжил, туслалцаа, сургалтын газраас зохион байгуулсан “Дижитал нотлох баримт болон Зэрлэг ан амьтдыг худалдаалах, Мөнгө угаах гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалт
- Азийн хөгжлийн банкнаас “Худалдаанд суурилсан мөнгө угаахтай тэмцэх нь” сэдэвт сургалт



III УЛИРАЛ

- АНУ-ын төрийн департаментаас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлээр мөрдөн шалгах чиглэлээр дэмжлэг үзүүлэх сургалт, хамтын ажиллагааны талаарх хэлэлцүүлэг
- Санхүүгийн үйлчилгээний сайн дурын корпусаас зохион байгуулсан “Ам.долларын корреспондент банкны харилцааг бэхжүүлэх” чиглэлээр сургалт



IV УЛИРАЛ

- Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн “Дата мэдээлэлд дүн шинжилгээ хийх шинэлэг аргууд” сэдэвт цахим сургалт
- АНУ-ын Сангийн яамны зөвлөхүүдтэй хамтран “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр сургалт”
- Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн “Типологийн жилийн уулзалт”



ШИГТГЭЭ 1. “ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ АШИГЛАН МӨНГӨ УГААХ НЬ” ТИПОЛОГИЙН ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛЛАА

Үл хөдлөх хөрөнгө ашиглан мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх нь хууль бусаар олсон орлогыг нуун далдлах хамгийн эртний аргуудын нэг гэж үздэг. ФАТФ-ын мэдээлснээр 2011-2013 оны хооронд дэлхий даяар хураагдсан хууль бус хөрөнгийн гуравны нэгийг үл хөдлөх хөрөнгө эзэлж байжээ. Үл хөдлөх хөрөнгийн салбарт нэг удаагийн гүйлгээгээр их хэмжээний мөнгө угаах боломжтой ба санхүүгийн салбартай харьцуулахад харьцангуй хяналт сул байдаг тул гэмт хэрэгтнүүд үл хөдлөх хөрөнгийг мөнгө угаах түгээмэл арга хэрэгсэл болгон ашигладаг байна. Түүнчлэн үл хөдлөх хөрөнгийн салбарын онцлог шинжүүд нь тус салбарыг мөнгө угаах гэмт хэрэгт өртөмтгий болгодог. Монгол улсын 2020 оны Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр үл хөдлөх хөрөнгийн салбарын аюул занал хамгийн өндөр, эмзэг байдлын үнэлгээгээр дунджаас дээш буюу өндөр эрсдэлтэй хэмээн үнэлсэн. Тус салбар нь хожуу зохицуулалтад орсон салбар бөгөөд тухайн салбарыг ашиглан мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх аюул заналыг өндөр хэмээн үнэлсэн байна. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь мөнгө угаах гэмт хэргийн үл хөдлөх хөрөнгийн салбарт, цаашлаад нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг харгалзан энэ төрлийн гэмт хэрэг хэрхэн үйлдэгддэг, гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэлийг бууруулахын тулд ямар арга хэмжээ авах хэрэгтэйг ойлгох нь чухал юм.

Санхүүгийн мэдээллийн алба мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй байгууллагууд болон мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд зориулан үл хөдлөх хөрөнгө ашиглан мөнгө угаахтай холбоотой эрсдэлийн үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, сэжигтэй гүйлгээг оновчтой таньж илрүүлэх, мэдээлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү типологийн тайланг боловсруулав. Тус типологийн тайланд үл хөдлөх хөрөнгийн зах зээл, салбарын онцлог эрсдэл, тус салбарыг ашиглан гэмт хэрэг үйлдэх түгээмэл аргууд, салбарын гадаад, дотоодын типологиуд, шинж тэмдгүүд, сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэхэд анхаарах зүйлс зэргийг дэлгэрэнгүй тусгав.

4.2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ АЖИЛТНУУДЫН ХАМРАГДСАН СУРГАЛТ, СЕМИНАР

Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд 2023 онд гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар, Эгмонт бүлэг, Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Олон Улсын Валютын сан, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудаас зохион байгуулсан мэргэжлийн сургалт, семинарт тогтмол хамрагдан, ур чадвараа сайжруулан ажиллалаа. Түүнчлэн Санхүүгийн мэдээллийн албанаас АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны хөтөлбөрөөр дамжуулан ажилтнуудын мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх, сүүлийн үеийн чиг хандлагын талаар мэдлэгээ дээшлүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна.

Хүснэгт 12. Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын сургалт, семинарт хамрагдсан байдал

Ажилтнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хамрагдсан сургалт, семинарын тоо	2021	2022	2023
	36	41	20

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнуудын 2023 онд хамрагдсан сургалт, семинараас онцлон дурдвал:

- Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) дахь бүс нутгийн сургалтын төвөөс БНХАУ-д зохион байгуулсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нь" сэдэвт сургалт;
- АНДМУТБ-аас зохион байгуулсан "Дата мэдээлэлд дүн шинжилгээ хийх шинэлэг аргууд" цахим сургалт;
- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх нь" сургалт;
- ОУВС-ийн Сингапур Улс дахь бүс нутгийн сургалтын төвөөс Эцсийн өмчлөгчийн ил тод байдлын зохицуулалтыг сайжруулах талаар сургалт;
- Улсын ерөнхий прокурорын газар болон АНУ-ын Хууль зүйн яамны Прокурорын хөгжил, туслалцаа, сургалтын газраас зохион байгуулсан "Дижитал нотлох баримт болон зэрлэг ан амьтдыг худалдаалах, мөнгө угаах гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх ажиллагаа" сэдэвт сургалт.

ТАВДУГААР БҮЛЭГ


**МЭДЭЭЛЛИЙН
СИСТЕМИЙН БҮТЭЦ**

5.1. МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛ /гоАМЛ/

Санхүүгийн мэдээллийн алба нь мэдээлэл хүлээн авах, дүн шинжилгээ хийх, шилжүүлэх ажлыг боловсронгуй болгох зорилгоор НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газраас (UNODC) мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд тусгайлан зориулж боловсруулсан гоАМЛ программыг 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс албан ёсоор нэвтрүүлэн ажиллаж байна.

гоАМЛ программ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан гүйлгээний талаар мэдээлэх үйл ажиллагааны чанарыг сайжруулж, тайлан мэдээлж буй мэдээлэх үүрэгтэй этгээдийг бүртгэх, хуулийн хүрээнд гүйлгээний тайлан, нэмэлт мэдээллийг мэдээлэх, хүлээн авах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, үндэслэл бүхий гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг хууль сахиулах байгууллагад шилжүүлэх үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэх цогц систем юм.

Зураг 13. гоАМЛ программын цахим хуудас



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Тайлант хугацаанд Санхүүгийн мэдээллийн алба банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдийг гоАМЛ программд бүртгүүлэх чиглэлээр анхаарч ажилласан бөгөөд 2023 оны сүүлийн байдлаар нийт 943 мэдээлэх үүрэгтэй этгээд гоАМЛ программд бүртгүүлж, холбогдох тайлан мэдээллийг хууль, журмын дагуу мэдээлж байна. Энэхүү үзүүлэлт нь өмнөх оноосоо ойролцоогоор 2 дахин өссөн бөгөөд дэлгэрэнгүй статистик мэдээллийг (Зураг 14)-аас харна уу.

Мэдээлэх үүрэгтэй этгээдийн ГоАМЛ программд бүртгүүлсэн байдал:



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба /2023-12/



МОНГОЛБАНК
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

Түүнчлэн банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдийн мэдээлдэг тайлангийн чанарыг сайжруулах зорилгоор хуульд заасан гүйлгээний мэдээллийг гоАМЛ программаар мэдээлэх, тайланг зөв, чанартай бөглөж илгээх чиглэлээр салбар тус бүрт зориулан сургалт, семинарууд шат дараатай зохион байгуулсан. Тухайлбал, Санхүүгийн мэдээллийн албанаас мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай мэдээлэх үүрэгтэй этгээдэд “гоАМЛ платформыг ашиглах зөвлөмж, тайлан мэдээлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудал” сэдэвт сургалтыг 2023 оны 07 дугаар сарын 3-5-ны өдрүүдэд зохион байгуулав. Тус сургалтад банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгал, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, үнэт цаасны зах зээлд оролцогч, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн 150 гаруй төлөөллүүдийг хамруулснаар уг салбарын мэдээлэх үүрэгтэй этгэдүүдээс ирүүлдэг тайлангийн тоо, чанарыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.



ШИГТГЭЭ 3. гоАМЛ ПРОГРАММ

гоАМЛ программын гарын авлагууд

Санхүүгийн мэдээллийн албанаас гоАМЛ программыг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор дараах гарын авлагуудыг боловсруулж, программын “Тусламж” цэсэд байршуулан, мэдээлэх үүрэгтэй этгээдэд хүргүүлэв.

I хэсэг » Бүртгэх

II хэсэг » Хэрэглэгчийн эрхийн удирдлага

III хэсэг » Тайлан бөглөх

IV хэсэг » Нэмэлт мэдээллийн файл тайлан бөглөх

V хэсэг » Виртуал хөрөнгийн үйлчилгээ
үзүүлэгчдэд зориулсан



ЗУРГААДУГААР БҮЛЭГ

**ХЯНАЛТ
ШАЛГАЛТ**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь тус хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын талаар нэгдсэн статистик гаргах, хяналт шалгалт хийх, эрх бүхий бусад этгээдээр хяналт шалгалт хийлгэх чиг үүрэгтэй. Мөн тус хуулийн 19.1-д мэдээлэх үүрэгтэй этгээд тус хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын нотариатчдын танхим, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Санхүүгийн мэдээллийн алба эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэхээр заасан байдаг. Тус хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь хяналт шалгалтын зохицуулагч байгууллагууд болох Монголбанкны Хяналт шалгалтын газар, Санхүүгийн зохицуулах хороо болон мэргэжлийн холбоодоос хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүлээн авч зайнаас хяналт тавьж, хамтарсан шалгалт хийх, газар дээрх хяналт шалгалтын мөрөөр цаашид авах арга хэмжээг хэлэлцэхэд санал өгөх, газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөө, стратегид санал, зөвлөмж хүргүүлэх хэлбэрээр хамтран ажиллаа.

Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт ФАТФ-ын зөвлөмжид нийцтэй байдлаар эрсдэлд суурилсан арга хэлбэрт бүрэн шилжсэн бөгөөд хяналт шалгалтын журам, гарын авлагыг сайжруулах чиглэлээр тасралтгүй анхаарч ажиллаж байна. Санхүүгийн мэдээллийн алба нь мэргэжлийн холбоодтой хяналт шалгалтын журам, гарын авлагын төслийг боловсруулах, журамд санал өгөх хэлбэрээр тогтмол хамтран ажилладаг. Энэ хүрээнд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр зайнаас болон газар дээрх хяналт шалгалт хийх журам” 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А/06 дугаар тушаалаар батлагдсан байна. Монголын нотариатчдын танхим нь журмын төслийг боловсруулан Санхүүгийн мэдээллийн албанаас санал авсан бөгөөд бүх гишүүдийн хурлаар журмыг хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Түүнчлэн “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 22 дугаар тогтоолоор баталсан бөгөөд Санхүүгийн мэдээллийн алба тус журмын төсөлд санал хүргүүлэн хамтран ажиллав.

Монголын өмгөөлөгчдийн холбооны сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны ээлжит хуралдааны үеэр холбооны шинэ удирдлагуудад Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу өмгөөлөгчдийн хүлээх үүрэг, хариуцлага, холбооны хүлээх үүргийн талаар танилцуулга хийж, өмгөөлөгчдийн үйл ажиллагаанд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийх зайны болон газар дээрх хяналт шалгалтын журмыг батлах хэрэгцээ шаардлага болон загвар журмын төслийг танилцууллаа.

Түүнчлэн Санхүүгийн мэдээллийн албанаас 2023 оны 3, 4-р улиралд Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтран Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг 100 гаруй өмгөөлөгчдийн эрсдэлийн үнэлгээг хийж, түүнд суурилсан газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөг гаргуулахаар Монголын Өмгөөлөгчдийн холбооны Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэв.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь тус хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын нэгдсэн статистик гаргах чиг үүрэгтэй байдаг. Нийт мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт болон авсан арга хэмжээний мэдээллийг (Хүснэгт 13) харуулав.

Хүснэгт 13. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа /2021-2023 он/

Үзүүлэлт	2023 он	2022 он	2021 он
МУТС, УОХЗДТ үйл ажиллагаанд хийсэн зайны хяналтын нийт тоо	8,392	4,901	5,819
МУТС, УОХЗДТ үйл ажиллагаанд хийсэн зайны хяналтад хамрагдсан МҮЭ-ийн нийт тоо	9,102	4,968	6,418
МУТС, УОХЗДТ үйл ажиллагаанд хийсэн газар дээрх хяналт шалгалтын нийт тоо	231	99	95
МУТС, УОХЗДТ үйл ажиллагаанд хийсэн нийт газар дээрх хяналт шалгалтад хамрагдсан МҮЭ-ийн нийт тоо	231	96	317
Хяналт тавих эрх бүхий байгууллагаас МУТС, УОХЗДТ чиглэлээр гаргасан дутагдлыг арилгах талаар хүргүүлсэн албан шаардлага, сануулга, хугацаат үүрэг даалгаврын нийт тоо	505	427	269
Хяналт тавих эрх бүхий байгууллагаас МУТС, УОХЗДТ-тэй холбоотой асуудлаар тогтоосон акт, мэдэгдлийн нийт тоо	71	266	2
Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэсэн МҮЭ-ийн нийт тоо	19	3	1
Зөрчлийн тухай хуулийн дагуу авсан хөрөнгө, орлого хураах, торгох арга хэмжээний нийт тоо	154,500,000	20,000,000	60,000,000

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд зохицуулагч байгууллагуудын хянан шалгагчдыг эрсдэлд суурилсан хяналт шалгалт, хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны талаарх олон улсын байгууллагуудын цахим сургалт, семинарт хамруулснаас гадна мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд зориулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргийг таниулах, эрсдэлийг ойлгуулах сургалтуудыг зохион байгуулав. Тухайлбал Санхүүгийн мэдээллийн алба дангаараа болон АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны албаны зөвлөхтэй хамтран мэргэжлийн холбоодын комплаенс, хяналт шалгалт хариуцсан ажилтнуудад зориулан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ерөнхий ойлголт, зайн болон газар дээрх хяналт шалгалт хийх, эрсдэлийг үнэлэх сэдвээр гурван удаагийн сургалтыг зохион байгууллаа.



ШИГТГЭЭ 1. “КОВИД-19 ЦАР ТАХАЛТАЙ ХОЛБООТОЙ ҮҮССЭН МУТС ЭРСДЭЛ” СУДАЛГААНЫ ТОВЧ

Дэлхий дахинд үүсээд буй коронавируст цартахал (Ковид-19)-тай холбоотойгоор улс орнууд өөрийн орны эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тасралтгүй авч хэрэгжүүлж байгаагийн зэрэгцээ үүссэн нөхцөл байдалд тохируулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС)-тэй тэмцэх үйл ажиллагааг уялдуулах шаардлага үүсээд байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас мэдээлэх үүрэгтэй этгээдийн хяналтын тогтолцоо, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа уламжлалт бус хэлбэрээр хийгдэх болсноор гэмт хэрэг нэмэгдэх, шинэ төрлийн эрсдэл бий болох өндөр магадлалтай талаар анхааруулсан байна.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр засгийн газрууд татварын хөнгөлөлт үзүүлэх, нийгмийн халамжийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг хөнгөлөх зэрэг олон төрлийн бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлснээс гадна хүн хоорондын зай барих, хөл хорио зэрэг хязгаарлалтын арга хэмжээ авсан. Эдгээрээс шалтгаалж төлбөр тооцоо, банк санхүүгийн үйлчилгээ эрчимтэй цахимжсанаас МУТС гэмт хэргүүд дижитал хэлбэр рүү шилжсэн. Мөн засгийн газраас олгож буй мөнгөн болон эд материалын тусламж, дэмжлэг, хөнгөлөлт зэргийг зүй бусаар, мөнгө угаах зорилгоор ашиглах нөхцөл бүрджээ.

Монгол улсын хувьд мөн адил Ковид-19 цар тахлаас үүдэлтэйгээр иргэдийн санхүүгийн зан төлөв өөрчлөгдөж, цахим төлбөр тооцоо нэмэгдэж, мөнгө угаахтай холбоотой олон төрлийн эрсдэл, эмзэг сул тал үүссэн байна. Жишээлбэл, 2019-2022 онд залилах гэмт хэргийг цахим хэрэгсэл, интернет ашиглах, олон шатлалт сүлжээний бизнесээр халхавчлах аргаар үйлдэх нь нэмэгдсэн. Мөн цар тахалтай холбоотойгоор цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн төрлүүдээс өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүд, түүн дотроо залилах, виртуал хөрөнгөтэй холбоотой хэргүүд дийлэнх хувийг эзэлсэн байв. Нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, иргэдийн цахим хэрэглээ, хорио цээрийн дэглэм тогтоосон зэргийг ашиглан бусдын эд хөрөнгө өмчлөх, эзэмших эрхийг шилжүүлэн авах, зар сурталчилгаа болон цахим худалдааны хуудас ашиглан хуурах, хувийн мэдээллийн нууцлалд нэвтрэх зэрэг гэмт хэргүүд түгээмэл гарсан байна.

Цаашид мэдээлэх үүрэгтэй этгээдүүд Ковид-19 цар тахлын үед өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх суваг зэрэгтэй холбоотойгоор үүссэн МУТС эрсдэлээ зөв үнэлснээр дахин давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх, бууруулах боломж бүрдэнэ. Мөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа буюу харилцагчийг таньж мэдэх, гүйлгээнд хяналт тавих, сэжигтэй гүйлгээг илрүүлж мэдээлэх үйл ажиллагааг үр дүнтэй явуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой.



ШИГТГЭЭ 2. ОХУ-ТАЙ ХОЛБООТОЙ АВЧ БУЙ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

ОХУ, Украинтай холбоотой үүсээд буй нөхцөл байдлаас шалтгаалж 2022 оны 02 дугаар сараас эхлэн олон улсын байгууллагууд, улс орнууд, холбоод ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээг шат дараалалтай авч хэрэгжүүлсээр байна.

Олон улсын санхүүгийн системийг хамгаалах зорилгоор Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) болон Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс нийт 5 удаа мэдэгдэл гаргаж, Олон улсын санхүүгийн мэдээлэл дамжуулах хамтын нийгэмлэг (СВИФТ)-ээс ОХУ-ын 10 банкиг өөрийн сүлжээнээс хассан бол Эгмонт бүлгээс ОХУ-ын санхүүгийн мэдээллийн албаны эсрэг 6 хориг арга хэмжээ аваад байна. Монгол Улс нь уг байгууллагуудын гишүүн, оролцогч орны хувьд гаргасан шийдвэр, хориг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх үүрэг хүлээн ажиллаж байна.

Үүнээс гадна томоохон улс орнууд, тухайлбал АНУ, Их Британи, Канад, Австрали, Шинэ Зеланд, Япон, Өмнөд Солонгос, Сингапур болон Европын Холбоо нь ОХУ-ын эсрэг санхүүгийн, худалдааны, импорт, экспортын болон хилийн зэрэг төрөл бүрийн хориг арга хэмжээг авсаар байна. Хамгийн сүүлд буюу 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр АНУ-ын Сангийн яамны Гадаад хөрөнгийн хяналтын алба (ГХХА)-наас 300 орчим хувь хүн, хуулийн этгээдийг хоригт оруулсан нь дайнаас хойшхи хамгийн том хориг арга хэмжээ болж байна. Ингэснээр АНУ өнгөрсөн 2 жилийн хугацаанд нийт 4000 орчим этгээдийг хоригийн жагсаалтад орууллаа. Мөн АНУ-ын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр гаргасан Тушаал 14024-т оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу гадаадын санхүүгийн байгууллага нь ОХУ-ын цэрэг, дайны үйл ажиллагааг дэмжих үйлдвэрлэлийн салбартай холбоотой аливаа томоохон гүйлгээ хийсэн буюу дэмжсэн, үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд хоригт оруулахаар болсон байна. Өөрөөр хэлбэл хориг арга хэмжээг улам өргөтгөж, улс орнууд хоёрдогч хоригт орох эрсдэлтэй болжээ.

Европын Холбоо 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр ОХУ-ын эсрэг 12 дахь багц арга хэмжээг гаргасан. Ингэснээр нийт 1718 хувь хүн, 419 хуулийн этгээд хоригт орж, эдгээр этгээдийн хөрөнгийг царцаах болон хилийн хориг тавих арга хэмжээг авсан байна. Өнөөдрийн байдлаар 21.5 тэрбум еврогийн хөрөнгийг царцаасан бөгөөд дайныг санхүүжүүлэх орлогын эх үүсвэрийг хаах, батлан хамгаалах салбарт ашиглах бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг зогсоох зорилгоор ОХУ-ын экспорт, импортын гол бүтээгдэхүүнд хориг тавиад байна.

АНУ, Европын Холбоо болон бусад улсаас авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээг тухайн улсын иргэн, аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлж, хоригт орсон улсын аливаа этгээдтэй тодорхой харилцаанд орохгүй байх үүрэгтэй. Монгол Улсын хувьд бусад улсын авч буй хориг арга хэмжээг дагаж мөрдөх үүрэг хүлээх шаардлагагүй боловч ОХУ-ын аливаа хуулийн этгээд эсвэл иргэдтэй бизнесийн харилцаа тогтоох, хамтран ажиллах нөхцөлд дайныг дэмжиж, санхүүжүүлсэн, дээрх улсуудын авч буй санхүүгийн хориг арга хэмжээг дэмжихгүй байна гэж үзэн, шууд бус сөрөг үр дагавар гарах боломжтой. Түүнчлэн ОХУ-ын эсрэг олон улсын зүгээс тавьж байгаа санхүүгийн хориг арга хэмжээ, хязгаарлалтууд чангарснаар ОХУ-аас манай улсад нийлүүлдэг шатахуун, тосолгооны материал, эм, эмнэлгийн хэрэгсэл, цахилгаан эрчим хүч, хүнс зэрэг нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний төлбөрийг гүйцэтгэхэд хүндрэл үүсэх эрсдэлтэй юм.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

**МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ
ХӨТӨЛБӨР**

7.1. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22¹ дугаар зүйлийн 22^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор үндэсний хэмжээнд хэрэгжих “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр” (цаашид “Хөтөлбөр” гэх) батлагдсан.


Хөтөлбөрийг батлан, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх нь Улсын Их Хурлын 2020 оны 52 тоот тогтоолоор батлагдсан “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Улсын Их Хурлын 2021 оны 106 тоот тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Улсын Их Хурлын 2020 оны 23 тоот тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын Их Хурлын 2020 оны 24 тоот тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ач холбогдолтой.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа – 2050”-ын 4.3 дугаар зорилтод “Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлэх” хүрээнд “Мөнгө угаах болох терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо боловсронгуй болсон байх”-аар заасан.

Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд тодорхойлсон бага эрсдэлтэй салбаруудаас илүү өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн үйл ажиллагаанд төвлөрөн, эрсдэлд суурилсан хэлбэрээр хөтөлбөрийг боловсруулсан.

Хөтөлбөр нь дараах бүтэцтэй. Үүнд:

Зураг 15. Хөтөлбөрийн бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Хөтөлбөрийг ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмж, үр дүнтэй байдлын 11 шууд хэрэгжилт, Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүн болон олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийг үндэслэн боловсруулсан бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ялангуяа хөтөлбөрөөр дэвшүүлсэн зорилтуудад хүрэхэд өндөр түвшний улс төрийн оролцоо, хангалттай нөөц бололцоо болон төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой.

Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараах 8 зорилгуудыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

ЗОРИЛГО 1

МУТС/ҮОХЗДС-тэй холбогдох хувьсан өөрчлөгдөж буй эрсдэлийн ойлголтыг сайжруулах

ЗОРИЛГО 2

МУТС/ҮОХЗДСТ үүрэг, хариуцлага, эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх

ЗОРИЛГО 3

МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх дотоод болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх

ЗОРИЛГО 4

МУТС/ҮОХЗДС эрсдэлд суурилсан бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх

ЗОРИЛГО 5

Мэдээлэх үүрэгтэй этгээдэд суурилсан хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх замаар МУТС гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх

ЗОРИЛГО 6

ТС, ҮОХЗД-ийг санхүүхүүжүүлж болзошгүй үйлдлийг таних, мөнгө угаах үйлдлийг илрүүлэх ажиллагааг сайжруулах

ЗОРИЛГО 7

Суурь гэмт хэрэг нь эрсдэлтэй гэж үнэлсэн МУГХ-ийг мөрдөн шалгах, яллах, шүүхээр шийдвэрлэх болон хөрөнгө хураахтай холбоотой ажиллагааны чанарыг сайжруулах, ТС гэмт хэрэгт сонор сэрэмжтэй хандах

ЗОРИЛГО 8

МУТС/ҮОХЗДСТ, урьдчилан сэргийлэх зохистой бүтэц, зохион байгуулалт, чадавхийг бэхжүүлэх

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 тоот тушаалаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 194 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр баталж, батлагдсан төлөвлөгөөг холбогдох байгууллагуудад хүргүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, биелэлтийг жил бүр гарган, танилцуулж байхыг Санхүүгийн мэдээллийн албанд даалгасан.

Үүний дагуу Санхүүгийн мэдээллийн албанаас Үндэсний зөвлөл (ҮЗ), Хамтын ажиллагааны зөвлөл (ХАЗ)-ийн гишүүн байгууллагууд руу тус хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөг байгууллагын дотоод ажлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж, улирал бүр биелэлтийг ирүүлэн, хамтран ажиллах тухай 2023 оны 17 дугаартай албан бичгийг хүргүүлсэн.

Зураг 16. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд

▶ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ	▶ ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
▶ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ	▶ ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
▶ МОНГОЛБАНК	▶ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
▶ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА	▶ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР
▶ ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ	▶ МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОЛБОО
▶ ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ	▶ МОНГОЛЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧДЫН ИНСТИТУТ
▶ САНГИЙН ЯАМ	▶ МОНГОЛЫН НОТАРИАТЧЫН ТАНХИМ
▶ УЛСЫН ПРОКУРОРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР	▶ МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО
▶ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО	▶ ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
▶ ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР	▶ ГАДААДЫН ИРГЭН ХАРЬЯАТЫН ГАЗАР
▶ АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР	▶ ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР
▶ ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР	
▶ ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ЗӨВЛӨЛ	

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийн 5.5, 5.7 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөөний явц, биелэлтийг байгууллагууд улирал бүр ҮЗ, ХАЗ-ийн хурлаар танилцуулан, үнэлж дүгнэн ажиллалаа.

Зураг 17. Хөтөлбөрийн биелэлтийг ҮЗ, ХАЗ-ийн хуралд танилцуулсан байдал



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Санхүүгийн мэдээллийн албанаас төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлүүдийн талаар ХАЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцсэн бөгөөд тус хурлаар нийт биелэлт ирүүлж буй байгууллагуудад биелэлтийг заасан хугацаанд оновчтой, тодорхой байдлаар бичих, биелэлт ирүүлээгүй байгууллагууд биелэлтийг ирүүлэх асуудлыг анхаарч ажиллахыг ХАЗ-ийн дарга үүрэг болгосон. Үүний дагуу Санхүүгийн мэдээллийн албанаас 2024 оны 01 тоот албан бичгийг ҮЗ, ХАЗ-ийн гишүүн байгууллагуудад хүргүүлсэн болно.

Төлөвлөгөөний нийт **194** ажлаас **2023** онд хийж дуусгах **21** ажил, **2023** оноос эхлэн хэрэгжих **146** ажил, жил бүр хэрэгжих **28** ажил байна.


Хүснэгт 15. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжүүлэх хугацаа

Хэрэгжүүлэх хугацаа	2023	2023-2024	2023-2025	2023-2026
төлөвлөгөөнд тусгагдсан ажлын тоо	21	31	16	35
Хэрэгжүүлэх хугацаа	2023-2030	2024-2025	2023-2025	2024-2028
төлөвлөгөөнд тусгагдсан ажлын тоо	46	9	8	28

Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

Байгууллагуудаас ирүүлсэн биелэлтийг нэгтгэн үзэхэд нийт 194 ажлаас хэрэгжүүлж эхэлсэн 160 ажил, хийгдэж дууссан 13 ажил, эхлээгүй 21 ажил байна. Үүнээс 2023 онд хийгдэж дуусгах 21 ажлаас 8 ажил бүрэн биелсэн, 13 ажил хийгдэж байгаа бөгөөд хийгдэж эхлээгүй ажил байхгүй байна. Харин жил бүр хийгдэх нийт 28 ажлаас 24 ажил хийгдэж дууссан бол 4 ажил хийгдэж байна.

Зураг 18. 2023 онд хийгдэж дуусгахаар тусгагдсан ажлуудын биелэлтийн байдал



Эх сурвалж: Санхүүгийн мэдээллийн алба

2023 онд хийгдэж дууссан ажлуудыг дурдвал:

- Зэрлэг ан амьтдын хууль бус худалдаа, хүрээлэн буй орчин, уул уурхайтай холбоотой мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийг судалж, холбогдох арга хэмжээг авах;
- ФАТФ-ын зөвлөмж болон шууд хэрэгжилттэй холбоотой, зайлшгүй гаргах шаардлагатай статистик мэдээллийн жагсаалт гаргах;
- Санхүүгийн мэдээллийн “Финтел” холбоог байгуулсан бусад улс орнуудын сайн туршлагыг судлах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

- Тусгай зөвшөөрөлгүй, бүртгэлгүй цахим төлбөр тооцоо, мөнгө гуйвуулгын үйлчилгээ, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг илрүүлэх, мэдээлэл солилцох чиглэлээр хууль сахиулах байгууллагууд дөрвөлсөн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;
- Мөнгө угаах гэмт хэргийг бүртгэсэн, мөрдөн шалгасан, хяналт тавьсан, шүүхээр шийдвэрлэсэн байдлыг үнэлэх, гарсан ахиц, дутагдлыг тодорхойлох;
- Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгахтай холбоотой гаргасан заавар, гарын авлага шинэчлэх;
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд блокчейн хяналтын программыг нэвтрүүлэх;
- Гаалийн ерөнхий газрын орон тооны бүтцэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэл хариуцсан алба хаагч 5-аас багагүй, хилийн боомтуудад 1-ээс багагүй байхаар зохицуулалт хийж, мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, гаалийн хяналтын техник, тоног төхөөрөмжийг сайжруулах

Харин 2023 онд хэрэгжүүлж дуусаагүй ажлуудын хувьд хууль, журам эрх зүйн орчинд өөрчлөлт хийхэд хугацаа шаардсан, төлөвлөсөн хугацааг сунгах шаардлага гарсан гэх мэт шалтгааны улмаас тухайн жилд хийгдэж дуусаагүй байна.